MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,160.782... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.08.29. Мягмар. №143 (4757) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Өдөр +20
Шөнө +5

УЛС ТӨР

МОНГОЛЧУУД ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД АНХААРАЛ ХАНДУУЛЖ ЭХЭЛЛЭЭ

II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИД АМИА АЛДСААР Л БАЙХ УУ

V нүүрт

Дугаарын 60 мөр

## Ядаж нэхийгээ боловсруулчихдаг болохсон

О.УЯНГА

Зуны урин дулаан цагт нийслэлчүүд аялаж, зугаалж, хөдөө гарч халуун чулуу атгадаг. Хотоос зүүн тийшээ гарвал Баянзүрхийн товчоо өнгөрөөд Налайх явах замаас хонь, ямаа авчихаж байгаа юм. Харин баруун тийш гарвал 22-ын товчоо хавиас авна даа. Хонь, ямаагаа аваад тэр хавьдаа төхөөрүүлнэ. Мал төхөөрч, гэдсийг арилгаж, янзалж өгдөг хүмүүс тусдаа бий. Тэгвэл хотын эргэн тойрон хонь, ямаа зарж, төхөөрч байгаа газруудад нэхий, арьс хаа хамаагүй хаягдаж, өмхийрч, өтөж байна. Яагаад хаяад байгаа талаар асуухаар ямар ч үнэ хүрэхгүй. Бүр 500 төгрөгөөр ч авахгүй шүү дээ гэх юм. Өлөнтэйгээ бол эв нь таарвал 1000, 2000 төгрөгөөр өгдөг гээд байгаа.

Төгсгөл нь III нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

## СУГАЛААНД ЁНДООГҮЙ ХОЁР НАСТНУУДАД ОНООСОН "ЯЛ" ЦЭЦЭРЛЭГТ ЯВАХГҮЙ ШҮҮ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Х.НОРЖИН

"Монголын үрс маш олон болтугай" хэмээн ямар "тэнэг" нь хэлдэг байна аа. Бодит амьдрал дээр хүүхдийг тээж төрүүлж болох ч өсгөж хүмүүжүүлэх, боловсрол олгох тухайд байгаа ганц нэгийгээ хүний дайтай явуулахад бэрх аж. Учир нь бүх зүйл мөнгөөр хэмжигдчихээд үйл тамаа эдэлж сууна". Энэ бол арга үйлээ барсан залуухан эцгийн твиттер хуудсандаа бичиж үлдээсэн сэтгэгдэл. Бас төрдөө гомдож яваа хүний үг. Тэрбээр өөрийгөө харуул хамгаалалтын албанд хамгаалагчаар ажилладаг гээд хоёр настай ихэр хөвгүүдээ цэцэрлэгийн бараа харуулахын тулд сая төгрөгийн эрэлд мордоод олоогүй тухайгаа өгүүлжээ. Үнэндээ түүний ижил зовлон амсч яваа мянга мянган эцэг, эх бий.

Үргэлжлэл нь III нүүрт

ОНЦЛОХ МЭДЭЭ

## Ерөнхийлөгч Шадар сайдыг ажлаас нь чөлөөлөх саналыг буцаалаа

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатад санал буцаах тухай албан бичиг илгээжээ. Уг бичигт "Таны 2017 оны наймдугаар сарын 22-ны өдрийн ЗГ-1/115 тоот "Санал хүргүүлэх тухай" албан бичигтэй танилцлаа. Тус албан бичигт Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүхийг өөрийнх нь хүсэлтээр үүрэгт ажлаас нь чөлөөлөх санал илэрхийлж, танилцуулга, УИХ-аар хэлэлцэгдэх тогтоолын төслийг хавсаргасан байна. Миний бие Төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгчийн хувьд Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайдын үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлт гаргах болсон шалтгаан нөхцөлийн талаар мэдээлэл авсны үндсэн дээр зөвшилцөх шаардлагатай гэж үзэж байна" гэжээ.




| ХААН банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2435.00 | 2452.00 | ФУНТ | 3117.00 | 3199.00 |
| ЕВРО | 2835.00 | 2900.00 | РУБЛЬ | 39.70 | 41.60 |
| ИЕН | 22.17 | 22.69 | ЮАНЬ | 363.50 | 367.40 |

| Худалдаа хөгжлийн банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2428.00 | 2444.00 | ФУНТ | 3056.00 | 3178.00 |
| ЕВРО | 2825.00 | 2926.00 | РУБЛЬ | 39.69 | 43.32 |
| ИЕН | 21.70 | 22.68 | ЮАНЬ | 364.00 | 367.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

## Хорих ангид хүмүүжигчдийг гагнуурын сургалтад хамруулав

Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар нь Бүгд Найрамдах Турк Улсын Ерөнхий сайдын дэргэдэх Туркийн хамтын ажиллагаа зохицуулах агентлагтай (ТИКА) хамтран ажиллах, “Төмрийн цех” байгуулах гэрээнд гарын үсэг зуржээ. Хамтын ажиллагааны хүрээнд ТИКА-гийн Улаанбаатар дахь хөтөлбөр зохицуулах газрын буцалтгүй тусламжаар “Хорих ангийн үйлдвэрлэлийг дэмжих, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, дотоод эх үүсвэрийг бий болгох, хорих ял эдлэгсдийг ажлын байраар хангах”, гэм хорын хохирол төлбөрийг барагдуулах, мэргэжил олгох зорилгоор хорих ангиудын хамгаалалтын төмөр эдлэлүүдийг дотооддоо үйлдвэрлэх хүчин чадал бүхий “Төмрийн цех”-ийг 441 дүгээр ангид байгуулсан байна. Турк Улсын Анкара хотын Абиданпаша техникийн их сургуулиас ноён Мурат Ендем, Сабри Биеик, Аядин Фидан, Мехмэт Акман зэрэг багш нар ирж тус төмрийн цехэд ажиллах хүмүүжигчид болон алба хаагчдад 2017 оны өнгөрсөн сарын 17-ноос энэ сарын 25-ны өдрүүдэд "Гагнуурчин, токарьчин, төмөр хийц эдлэлийн суурь мэдлэг олгох" анхан шатны сургалтыг амжилттай зохион байгуулж, сургалтад хамрагдсан хүмүүжигчид болон алба хаагчдад сертификатыг нь гардуулан өгчээ. Энэхүү төмрийн цехийг байгуулж, хүмүүжигчид болон алба хаагчдыг сургалтад хамруулснаар алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хүмүүжигчдэд нарийн мэргэжил эзэмшүүлж, ажлын байраар хангах ач холбогдолтой юм.

ҮЙЛ ЯВДАЛ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# МОНГОЛЧУУД ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД АНХААРАЛ ХАНДУУЛЖ ЭХЭЛЛЭЭ

Н.БАТЗАЯА

Цэцэрлэгтээ өглөө цэнгээд явсан хүүхэд орой нь хоолны хордлого авчихаад ирдэг эмгэнэлтэй явдал манай улсад бий. Бүр анги нийтээрээ хоолны хордлогод орсон тохиолдол ч цөөнгүй. Энэ бүх асуудлын учир шалтгааныг эрэлхийлбэл хүнсний аюулгүй байдал хэмээх томоохон сэдэв хөндөгдөнө. Харин уг сэдэв манай улсад тулгамдаж буй хамгийн чухал асуудлуудын нэг билээ. Өдрөөс өдөрт өргөжин тэлж буй худалдаа, үйлчилгээний салбарт хяналт дутагдсанаас болж иргэд гарал үүслийн гэрчилгээгүй, хаана яаж хадгалсан нь мэдэгдэхгүй хүнсний бүтээгдэхүүнийг өдөр тутмын хоол хүнсэндээ хэрэглэдэг. Тэгвэл энэ цагт уг асуудлыг шийдвэрлэх арга замыг илэрхийлсэн Үндэсний хэмжээний чуулга уулзалтыг зохион байгуулахаар шийдвэрлэсэн билээ. Тодруулбал, Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын санаачилгаар “Монгол Улсын хүнсний аюулгүй байдал” сэдвээр ирэх сард үндэсний хэмжээний чуулганыг зохион байгуулах аж. Энэхүү үндэсний чуулган нь Монгол Улсын хүнсний салбарын өнөөгийн байдлыг тодорхойлох, хүн амын гол нэрийн хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах, хүнсний хангамжийг сайжруулах, хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр авах шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулж, шийдвэрлүүлэх зорилготой байна. Үндэсний хэмжээний чуулга уулзалтын хүрээнд “Мах, махан бүтээгдэхүүн, өндөг, гахай, тахианы мах үйлдвэрлэгчдийн тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлэг өчигдөр Төрийн ордонд боллоо.

Хэлэлцүүлэгт Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Баяртуяа болон махан махан бүтээгдэхүүн, өндөгний худалдаа эрхлэгчид оролцож, санал бодлоо солилцов. Энэ удаагийн салбар хуралдаанд нийт гурван сэдвийг хөндөн хэлэлцүүлсэн юм. Тухайлбал, “Төрөөс махны үйлдвэрлэлийн салбарт баримталж байгаа бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ”, “Мах төхөөрөх үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал”, “Мах боловсруулах салбарын өнөөгийн байдал” зэрэг сэдвээр салбарынхан хэлэлцүүлэг өрнүүлэв. Энэ үеэр “Түмэн шувуут” компанийн захирал Ж.Болд “Өнөөдөр бид хүнсний аюулгүй байдлын тухай авч хэлэлцэхээр цуглаад байна. Тиймээс өндөгний аюулгүй байдалтай холбоотой асуудалд анхаарлаа хандуулаасай гэж хүсч байна. Манай холбооны зарим хүмүүс ОХУ-аас хямд өндөг орж ирдэг. Энэ нь шувууны аж ахуй эрхлэгчдэд тулгамдсан асуудлын нэг гэлээ. Би түүнээс гадна нэг зүйлийг хэлэх гэсэн юм.

Сүүлийн үед Ази, Европын Голланд, Бельги, Их Британи, Герман зэрэг оронд шувууны аж ахуйнд ариутгалын бодис хэрэглэж байна. Уг ариутгалын бодисны нөлөөгөөр шувуу халдвар авах болсон. Үүнээс болж Европын орнуудад уг бодисоор ариутгасан шувууны өндгийг эргүүлэн татах шийд гаргаад байгаа. ОХУ-аас манай улсад хямдхан өндөг импортоор орж ирдэг. Оросууд барууны орнуудаас ариутгалын бодис худалдаж авч шувууныхаа ариутгалд хэрэглэж байгаа нь ойлгомжтой. Үүнээс шалтгаалж хямдхан өндөг манай улсад орж ирж байгаа юм биш үү. Үүнийг аюулгүй байдлын үүднээс шалгаж үзэх хэрэгтэй. Импортын асуудлыг тодорхой хэмжээнд шийдэх шаардлагатай байна. Энэ бол зөвхөн шувууны аж ахуй эрхлэгчдийн асуудал биш” гэв. Мөн тэрбээр Ерөнхийлөгчийн зөвлөх Л.Эрдэнэчимэгт дээрх асуудалд анхаарч ажиллах хүсэлтийг өгсөн юм. Харин мах махан импортлогчдын хувьд татварын асуудалд Засгийн газраас анхаарч, гадаадын улс орон дахь айлчлалынхаа үеэр тухайн улсынхаа холбогдох удирдлагуудад хүсэлт тавиач гэдэг саналыг онцолж байлаа.

Манай улсын хувьд мал аж ахуйг хөгжүүлэхэд анхаарч УИХ-аас 2009 онд “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, 2010 онд “Монгол мал” үндэсний хөтөлбөр, 2015 онд “Төрөөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ийг тус тус батлан хэрэгжүүлж байгаа билээ. Гэвч дээрх хөтөлбөр бодит амьдрал дээр төдийлөн биеллээ олохгүй байгааг мал аж ахуй эрхлэгчид хэлж байв. Манай улс он гарсаар БНХАУ, ОХУ болон Иран улс руу монгол малын махыг экспортолж эхэлсэн. Гэвч худалдаа эрхлэгчдэд монгол малын махыг импортлоход хил гаалиас эхлээд асуудал үүсдэг байна. Мөн өнөөгийн нийгэмд Худалдааны тухай хуулийг батлуулах нэн шаардлагатай байгаа ажээ. Уг хууль батлагдсанаар гадаад худалдааны үүд хаалга нээгдэнэ гэдгийг мэргэжилнүүд онцолж байлаа.

## Ээлжит бус чуулган хуралдана

УИХ-ын ээлжит бус чуулганыг хуралдуулах эсэхийг хэлэлцэх Зөвлөлийн хурал өчигдөр боллоо. Хуралдаанаар УИХ-ын чуулганыг зарлан хуралдуулах хуваарь гаргасан байна. Энэ талаар УИХ дахь МАН-ын бүлгийн дарга Д.Хаянхярваа "УИХ-ын даргын зөвлөлөөр асуудлыг шийдлээ. Маргааш Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 10:00 цагт хуралдаж, Шадар сайд, Ерөнхий сайдаас тавьсан хүсэлтийг хэлэлцэнэ. Мөн 14:00 цагаас намын бүлгүүд хуралдана. Харин нөгөөдөр Төрийн байгуулалтын байнгын хороогоор Засгийн газрын асуудлыг хэлэлцэхээр боллоо" хэмээн тайлбарлалаа. Хуваарь ёсоор өнөөдөр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 10:00 цагт хуралдах юм байна.

ШАР МЭДЭЭ

## С.Бямбацогт: Хамтдаа зүтгэнэ гэж амалж гарч ирчихээд хоорондоо хагаралдах нь утгагүй



МАН хоёр хуваагдаж, зарим хэсэг нь Засгийн газраа унагаж, Ерөнхий сайдаа огцруулахаар гарын үсэг цуглуулсан. Бүр УИХ-д өргөн барьчихаад байгаа. Тэгвэл Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт энэ асуудлаар байр сууриа илэрхийлж, ярилцлага өгчээ. Тэрбээр “Засгийн газрыг огцруулах асуудлыг УИХ дахь сөрөг хүчин биш нэг зорилго, нэг үйл хэргийн төлөө зүтгэж яваа бүлгийн нөхдөөс маань гаргаж тавьсныг гайхширч байна. Манай намынхан өөрсдөө өрөөлийн өрдсөн түймрийг унтраахын оронд үлээж хөгжөөгөөд байгаа нь тун ч зохисгүй байна. Ингэж байж “Жоомоо алах гээд байшингаа шатаав” гээчийн үлгэр болчих вий дээ. Үүнээс болж бусдын идэш, хоноцын хэвтэш болж хохирох вий гэдгээ ер нь бодож үзсэн л байгаа даа. Хамтдаа зүтгэж, хамтдаа хөгжинө гэж ард түмэндээ амлаж гарч ирчихээд өөр хоорондоо хагаралдаж үймэлдэх нь үнэндээ шал утгагүй шүү дээ. Улс гэрээ нурааж тоглох ямар хортойг өмнөх эрх баригчдын үед та бид хангалттай амссан. Тэр алдааг засч, ачааг үүрнэ гэж итгэсэндээ л ард түмэн МАН-д 65 суудал өгсөн гэдгийг хэзээ ч мартаж болохгүй. Удахгүй намын Бага хурал болж, улмаар намын Их хурлын товыг тэндээс зарлана. Харин намын Их хурлаас намын шинэ даргаа сонгох нь тодорхой шүү дээ. Тэр шинэ хүн нь хэн болдог юм тэр нь л Засгийн газраа тэргүүлээд, төрийн бодлогоо хэрэгжүүлээд явна биз” хэмээн ярьжээ.

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

# А.ХАЛИУНАА: “ДЭЛХИЙН УР ЭЗЭМШИГЧДИЙН ЧАДВАР

Д.ТӨВ

*Арабын нэгдсэн Эмират улсын Абу Даби хотод зохиогдох "Дэлхийн ур чадвар" олон улсын тэмцээнд манай улс энэ жил зургаан мэргэжлийн төрлөөр оролцохоор бэлтгэлээ хангаж байна. Тэмцээнд оролцогчдод тэмцээний дүрэм, (мэргэжлийн талбай, байрлах байр, орчин, хоол) сэтгэл судлал, тэмцээний сэтгэл зүй, багийн ажиллагаа, манлайлал, харилцааны соёл, бясалгал, йогийн дасгал, гэх мэт сургалтыг саяхан зохион байгууллаа. Энэ үеэр тус тэмцээний Монгол Улсын албан ёсны төлөөлөгч, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ)-ны Мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтсийн дарга А.Халиунаатай ярилцлаа.*

**-“Дэлхийн ур чадвар”-ын тэмцээнд манай улс хоёр дахь удаагаа оролцох гэж байна. Энэхүү тэмцээн хэзээнээс эхлэн зохион байгуулагдах болсон талаар товч мэдээлэл өгөхгүй юу?**

-Дэлхийн хоёрдугаар дайны дараа буюу 1946 онд Испанид чадварлаг ажилчид ус, агаар шиг хэрэгтэй болж л дээ. Испанийн залуучуудын холбооны дарга нь энэ хэрэгцээг олж харан, чадварлаг залуу үеийг шат дараатай бэлтгэн гаргах, тэдэнд урам зориг өгөхүйц томоохон ажил зохион байгуулахаар шийдсэн нь энэхүү "Дэлхийн ур чадвар" олон улсын тэмцээн юм. Хоёр жилд нэг удаа зохион байгуулагддаг тус тэмцээнд оролцогч орны тоо жилээс жилд нэмэгдсээр одоо 77 орон болсон байгаа. Уг тэмцээнийг өдөртөө давхардсан тоогоор 30 мянга орчим хүн үзэхээр ирдэг юм байна лээ. Харин тэмцээнд оролцогч болон зохион байгуулагчид нийлээд 6000 орчим хүн хамруулж чаддаг маш том тэмцээн юм. “Дэлхийн ур чадвар”-ын тэмцээнд гагцхүү МСҮТ, Политехник коллежийн, суралцагчид болон төгсөгчид оролцдогоороо онцлогтой. Манай улсын хувьд 2014 онд 69 дэх гишүүн орноор элссэн. Энэхүү тэмцээн нь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв болон Политехник коллежид суралцагчдад урам зоригийг нэмэх, тэднийг хөгжүүлэх, ур чадвараа Монгол Улсад төдийгүй олон улсад сорих, мөн мэргэжлийн боловсролын салбарын суралцагчид ямар их ур чадвартай мундаг гэдгээ залуучуудад болон олон нийтэд таниулах, түүгээрээ ур чадвартай мэргэжилтэй ажилтны нэр хүнд, үнэ цэнийг өсгөх зорилготой юм.

**-Өнгөрсөн хугацаанд манай улс хичнээн тэмцээн, уралдаанд оролцов. Ямар амжилт үзүүлсэн бэ?**

-Монгол улс 2015 онд анх удаа үсчин, гоо сайхан, тогооч, гагнуур, хавтанцар, өрөг угсралт, мужаан, цахилгаан, токарь нийт есөн мэргэжлээр оролцсон. Анх удаа оролцож байгаа орон зочин, ажиглагчийн байр сууринаас оролцдог юм. Тиймээс бид анх удаа оролцохдоо туршлага судалж, монгол хүүхдүүд хаана ямар түвшинд байгаагаа тодорхойлж мэдэж авсан нь манай улсын баг анхны тэмцээндээ бидний хувьд маш амжилттай оролцсон гэж бодож байгаа. Тухайлбал, шагналт байранд орохын тулд 500 оноо авдаг бол мужааны төрөлд оролцсон Д.Нармандах 480 авсан, "Дэлхийн ур чадвар" тэмцээний шүүлтийн нэг онцлог нь босго оноонд хүрсэн бол хэдэн ч хүн байр эзэлж болдог. Хэрэв манайх 500 оноонд хүрсэн бол тусгай байр эзлэх байсан. Энэ жилийн хувьд манай улс мужаан, гагнуур, өрөг угсралт, сантехник, цахилгаан, тогооч гэсэн зургаан мэргэжлээр оролцохоор “Монгол ур чадвар” тэмцээнийг дотооддоо үе шаттайгаар явуулж, шилдгүүдээ шалгаруулж, бэлтгэлийг нь хангуулж эхлээд байна. Хоёр дахь удаагаа оролцох гэж байгаа учир өмнөх амжилтаа ахиулах зорилттой байгаа.

**-Оролцогчдыг хэрхэн шалгаруулдаг юм бэ. Шүүлт нь шударга болж чаддаг уу?**

-Шүүлт нь ил, тод, бүгдэд ойлгомжтой, тодорхой удирдамжийн дагуу, дэлхийн ур чадварын тэмцээний даалгавраар зохион байгуулагддаг. 2017 оны оролцогчийг 2016-2017 онд улсын хэмжээнд үе шаттайгаар "Монгол ур чадвар" тэмцээнээр шалгаруулсан. Мужааны мэргэжлийн оролцогчийг жишээ нь "Модны чадавхийн төв"-тэй хамтран гурван үе шаттайгаар зохион байгуулж шалгаруулсан. 41 мянган оролцогчийг энэ мэтээр мэргэжил тус бүрээр нь шалгаруулдаг гэж ойлгоход болно. МСҮТ, политехник, коллежийн суралцагчид энэ тэмцээнийг жилээс жилд сонирхон, хичээн суралцаж байна. "Бидэнд ч гэсэн ийм боломж байгаа юм байна" гэдгийг ойлгож эхэлж байгаад баяртай байдаг.

**-Тэмцээнд оролцогчдын зардлыг хаанаас гардаг юм бэ. Тусалж дэмждэг, хамтран ажилладаг байгууллага бий юу?**

-"Дэлхийн ур чадвар"-ын тэмцээнд оролцогчдыг сонгон шалгаруулах урьдчилсан тэмцээний ерөнхий зохион байгуулагч нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. Энэхүү тэмцээнийг анхнаас нь дэмжиж, санхүүжилтийнх нь дийлэнх хэсгийг Германы хамтын ажиллагааны нийгэмлэг болон Оюутолгой компани шийдэж өгч байгаа. Шилдгээр шалгарсан оролцогчид

MMINFO.
МОНГОЛЫН МЭДЭЭ
19 дэх жилдээ
Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО
Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158
Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012
Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454
Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873
Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796
Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710
Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510
Э.САЙНЗАЯА 99197866
Дугаарыг эрхэлсэн Н.ПУНЦАГБОЛД
Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757
Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот
“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ҮЗЭЛ БОДОЛ

# СУГАЛААНД ЁНДООГҮЙ ХОЁР НАСТНУУДАД ОНООСОН “ЯЛ” ЦЭЦЭРЛЭГТ ЯВАХГҮЙ ШҮҮ

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Миний охин ч тэдний нэг. Цэцэрлэгийн цахим сонголтод сонгогдож чадсангүй гээд охин минь охиноо тэвэрсээр уйлсаар орж ирсэн. Хүүхдээ хараад хоёр жил гэртээ таг суусан охин минь охиноо цэцэрлэгт өгчихөөд ажилдаа орно хэмээн хэчнээн их баяр хөөртэй байсан гээч. Харамсалтай нь хаалган төрийн харанхуй бодлогын гайгаар дахиад л гэртээ суух болж. Тодруулж хэлбэл, зээ минь цэцэрлэгийн цахим сугалаанд бүдэрсэн хэрэг. Бачимдаж, гомдсон эцэг эх хоёр нь муу зээг минь “ёндоогүй”, азгүйгээр нь дуудаж бидний уурыг барав. Ирэх жил аз гээч нь таарахгүй бол үргэлжлүүлээд л гэртээ сууж таарна. Гэвч зээ минь ирэх жил гурав хүрч цэцэрлэгт элсэх эрх нь бүр хаагдах юм билээ. Гэхдээ бид асуудлыг шийдсэн. Хоёр талын эмээ өвөө нь нийлж байгаад зээгээ хувийн цэцэрлэгт өгч, эхийг нь ажилд нь оруулахаар ярилцлаа. Ийм боломж бололцоо гэр бүл бүхэнд байхгүй нь бодит үнэн. Хоёрхон хоногийн дараа хичээлийн шинэ жил эхлэнэ. Эрдмийн их өргөө мөнгөн хонхоо жингэнүүлэн бяцхан үрсээ хүлээж авна. Харин их өргөөний босго алхах эрхээ хасуулсан, хандив эсвэл хахуулын мөнгөгүй эцэг, эхтэй хоёр настнууд хэний хаалгыг тогших болж байна вэ. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулж байгаа мэдээллээр бол 201-2018 оны хичээлийн шинэ жилд зөвхөн нийслэлийн хэмжээнд 34 мянган хоёр настан сургуулийн өмнөх боловсролд хамрагдах агаад тэднээс дөнгөж 12 мянга гаруйг нь цэцэрлэг хүлээж авах бололцоотой гэнэ. Өчигдөр 2015 оны буюу хоёр настнуудын цэцэрлэгийн онлайн бүртгэлийн сугалаа албан ёсоор өндөрлөж, аз гийсэн өөрөөр хэлбэл ёндоотой нөхдүүдийг бүртгээд эхэлсэн. Сугалаанд ёндоорсон хүүхдүүдийн эцэг, эхийн царайд баяр гийн, нүүр дүүрэн мишээл тодруулж байхад азгүй хүүхдүүдийн эцэг, эх миний охины адил хүүхдээ тэвэрсээр хүүхдийнхээ азгүйг дуудсаар харьсан биз ээ. Цухалдлаа гээд ч яалтай билээ. Монгол Улсад хүүхэд бүр цэцэрлэгт хамрагдах боломж нэгэнт байхгүй хойно. Нийслэлийн хэмжээнд өдгөө төрийн өмчийн 216 цэцэрлэг, төрийн бус 407 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаа нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн тоотой харьцуулахад дэндүү гэмээр үзүүлэлт. Тэр бүү хэл, нийслэлд хороондоо ганц ч цэцэрлэггүй бүхэл бүтэн 20 хороо байна гээд төсөөл дөө. Тэдний ихэнх нь шинээр ашиглалтад орсон орон сууцны шинэ хорооллууд. Тухайлбал, “Баянмонгол”, “Олимп”, “Их Монгол” ,”Жаргалан” “Хурд”, “Нарны хороолол”-ыг дурдах байна. Энэ бол зөвхөн ХУД-ийн нутаг дэвсгэрт сүндэрлэсэн хорооллууд. Тэгэхээр эдгээр хорооны хүүхдүүд хаана, хэнд хандах болж байна вэ. Эдгээр хорооллуудад 12 мянган сургуулийн өмнөх насны хүүхэд аж төрдөг. Тэд ХУД-ийн нутаг дэвсгэрт шинээр ашиглалтад орсон 218 дугаар цэцэрлэгт харьяаллынхаа дагуу хамрагдах учиртай. Гэтэл өнөөх цэцэрлэгийн багтаамж 120 хүүхэд. Амьд хүн аргатай юм хойно, тэдний дөрвөн мянга орчим нь хувийн цэцэрлэгт, хоёр мянга орчим нь хүүхэд харах үйлчилгээнд, мянга орчим нь эмээ, өвөөгөө бараадна гэвэл үлдсэн хүүхдүүдийн хувь заяа хэрхэхийг бурхан мэдэх нь ээ дээ. Дээр нь өнгөрсөн жил, түүний өмнөх жил ч цэцэрлэгт хамрагдаж чадаагүй гурав, дөрвөн настнууд гэж бий. Эднийг нэмэхээр сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж чадаагүй багачуудын тоо дунджаар хоёр мянга орчмоор нэмэгдэж таарна. Энэ бол зөвхөн нэг дүүргийн асуудал. Ингээд л харж хандах хүнгүй, төрдөө шоовдорлогдсон багачууд өөрөө өөрийгөө харж, хаалга хэзээ дуугарахыг хүлээх тавилангаа эдэлнэ. Бас нэг хэсэг нь гэртээ түгжигдэнэ. Яах вэ, орон сууцанд амьдардаг айлын хүүхдүүдийн хувьд тагт нь хаалттай, цахилгааны залгуур, индүү, угаалгын автомат машин зэргээр тоглочихгүй бол байгаад л байх биз. Харин гэр хороололд аж төрдөг айлын хувьд сэтгэл түгшээх зовлон олон бий. Шүдэнзээр тоглож гал алдахаас өгсүүлээд зуух, халуун тогоондоо түлэгдчих гээд байдаг. Өнгөрсөн жил нийслэлийн хэмжээнд 13 хүүхэд гэртэйгээ шатаж амь насаа алдсан бол 140 гаруй хүүхэд их бага хэмжээгээр угаартаж, эмнэлгийн тусламж авснаас гадна мянга гаруй хүүхэд халуун тогоо, буцалсан усанд түлэгдэж, эрүүл мэндээрээ хохирчээ. Хэрэвзээ тэд гүйгээд очих цэцэрлэгтэй, аваад үлдэх эмээ өвөөтэй байсан бол өвдөж шаналахын зовлонг эдлээ ч бил үү. Хатуу үнэнийг хэлэхэд, Цоожтой хаалганы цаана нулимстай суух “ял сонсоод” байгаа мянга мянган хүүхдийг Монголын төр "Сугалаанд ёндоогүй" хэмээн хэдий болтол даажигнах юм бэ. Тэд эх орныхоо ирээдүй болох гэж энэ хорвоод мэндэлсэн биш, энэ нийгэмд шоовдорлогдох гэж мэндлээгүй байлтай. Хэдий болтол Монголын үрс жил, жилийн намар сугалааны хонжвор болж, цоожтой хаалганы цаана уйлж суух ёстой юм бэ. Хэдий болтол цэцэрлэгийн насныхан "Хүрэлцээгүй орон тоон" дээр "алалцах" ёстой юм бэ. Хэлээд өгөөч, дарга нар аа. Ингэхэд бид чинь “Эцэг эх нь НӨАТ-ын сугалаатай

Энхрий үрс нь цэцэрлэгийн сугалаатай

Энгийн иргэд нь газрын сугалаатай” орны иргэд болоо юу даа. Хэн бүхэнд аз таараад цэцэрлэг сургууль нь элбэг байдаг бол хэн ч юу ч хэлэхгүй, бас гомдлохгүй. Нөгөөтэйгүүр, цаг үеэ дагаад цэцэрлэг сургуулийн багш нарын бизнес хэрээс хэтэрч. Хичээлийн шинэ жил ойртох тусам тэд үнэд орж, хандивын ангид орвол ор. Хандив нь сая төгрөг гэж байх юм. Гэхдээ ханшийн хувьд байршлаас хамааралтай гэнэ билээ. Гэр хороолол дундах цэцэрлэгийн хандив 300-500 мянга байх жишээний. Хотын төв бол саяас дээш гэж дуулдсан. Тэгэхээр боловсролын салбар хэдийнэ авлига хээл хахуульд идэгдсэн байгаа биз. Асуудал үүгээр дуусахгүй. Арга үйлээ барж сургуулийн өмнөх боловсрол эзэмшсэн нөхдүүд хэдэн жилийн дараа ерөнхий боловсролын сайн сургуульд элсэх асуудалтай тулгарна. Эцэг, эх бүхэн хүүхэддээ сайн боловсрол олгож, тэр хэрээр сайн сайхан амьдралд хөл тавиулахыг хичээдэг нь нууц биш. Тиймээс ЕБ-ын нэг, орос-3, 18, 23,24, 84,33 дугаар сургуульд элсүүлэхийг хичээдэг. Дээр нь Кембержийн гэх тодотголтой лаборатори сургуулиудыг нэрлэх байна. Эдгээр сургуулиудын элсэлтийн хахуулийн ханш хавар гурван сая байсан бол өдгөө таван саяар хэмжигдэх болж. Таван саяа бариад ирвэл асуудалгүй гээд хээв нэг сууж байх юм, захирал, сургалтын менежерүүд нь. Нэгдүгээр сургуулийн нэг багшид сая төгрөг өгье гэсэн эцэгт “наад мөнгө чинь үдийн хоолтой л тэнцэнэ шүү дээ” хэмээн томорсон дуулдсан. Ингэж хэлэхээр хахуульд өгдөг мөнгөө хувийн сайн сургуульд өг гэх хүн байж мэднэ. Жилийн таван сая төгрөгийн төлбөр төлөөд байх эдийн засгийн чадавхитай гэр бүл манай улсад хэд билээ. Тэгээд ч олон улсын хамтарсан хөтөлбөртэй бол төлбөр нь валютаар хэмжигддэгийг хэн бүхэн мэднэ.

...Нөгөөтэйгүүр, цаг үеэ дагаад цэцэрлэг сургуулийн багш нарын бизнес хэрээс хэтэрч. Хичээлийн шинэ жил ойртох тусам тэд үнэд орж, хандивын ангид орвол ор. Хандив нь сая төгрөг гэж байх юм. Гэхдээ ханшийн хувьд байршлаас хамааралтай гэнэ билээ. Гэр хороолол дундах цэцэрлэгийн хандив 300-500 мянга байх жишээний. Хотын төв бол саяас дээш гэж дуулдсан...

Ийм нөхцөл байдалд бидний үрс боловсрол олж авах гээд зүтгэж байна даа. Өгдөг боловсрол нь чанартай, авдаг цалин маань сургалтын төлбөр төлөхөд асуудалгүй бол юу боллоо гэж боловсролын тогтолцоо, төр засаг руугаа дайрхад хүрэх билээ. Аль нь ч бидний хэрэглээг хангаж чадахгүй юм даа. Уг нь гуравхан сая хүн, тэр дундаа сая дөнгөж гарах хүүхдийн асуудал юмсан. Шийдэх улс төрийн хүчин энэ хорин жилд гарсангүй. Тэр бүү хэл, шийднэ гээд төрд гарсан түшээд нь хүртэл гарсан хойно оо өөрийн хүүхдийн боловсролыг л өөд татаж, гадаадад сургуульд явуулах арга замыг эрэлхийлэхээс биш түмний үрсийн төлөө хуруугаа ч хөдөлгөдөггүй. Ийм л цаг дор та бид амьдарч байна. Бачимдахдаа ад үзээд байсан социалист нийгмээ үгүйлэх л юм. Сайхан зүйлийг ухрааж болдог бол БНМАУ-ын боловсролын тогтолцоог хэрэгжүүлэхсэн. Ядах нь хахуул өгөх гэж өр зээл тавьж, арга үйлээ барахгүй биз.

Дугаарын 60 мөр

## Ядаж нэхийгээ боловсруулчихдаг болохсон

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Түүнээс илүү үнэ хүрэхээ больчихож. Ямар сайндаа л хонины нэхийгээ хаа хамаагүй зүгээр хаяж, өмхийрүүлж байх вэ дээ. Монгол Улс уг нь хөдөө аж ахуйн орон. 50, 60 сая мал тоолуулдаг. Түүнийх нь ихэнх хувь нь бог мал. Гэтэл Монголд хонины нэхийгээ хагас боловсруулчих олигтой үйлдвэр байна уу. Баахан л арьс, ширний үйлдвэртэй гээд байдаг.

Тэр нь хаачив. Нэхий тоож авдаггүй хэрэг үү. Зөвхөн хотод гэлтгүй хөдөө орон нутагт ч нэхий талхны үнэд хүрэхээ больчихож. Уг нь хонины нэхийгээ боловсруулаад зардаг бол үнэд хүрнэ. Бүр цаашлаад эцсийн бүтээгдэхүүн болгоод дотоод, гадаад руу зардаг бол аятай юу. Монголд одоогоор “Дархан нэхий”, “Дархан минж” тэргүүтэй хоёр гуравхан компани нэхий бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Харамсалтай нь эдгээр компаниудын бүтээгдэхүүн хэтэрхий үнэтэй. Жаахан загварлаг талдаа нэхий дээл бол саяар яригдана. Цаашлаад сая давсан үнэтэй байх нь бий. Өөрсдөө бол боловсруулалт нь үнэтэй учраас гэж тайлбарлаад байдаг.

Түүнээс гадна олон төрлийн тайлбар хийнэ ээ, тэд чинь. Хэчнээн боловсруулахдаа үнэтэй байсан ч гэсэн нэг нэхий дээл 500, 600 мянга, цаашлаад сая төгрөг давсан үнэтэй байна гэхээр гайхаад байна л дээ. Нэхий нь үнэгүй байхад шүү дээ. Нэг талаасаа өрсөлдөөн дутагдаад байх шиг байна. Уг нь манайхаас олигтой оронд бол аймаг болгонд нэхий боловсруулах үйлдвэртэй баймаар байх юм. Тэгээд нэхийгээ боловсруулаад, нэмүү өртөг шингээгээд зарж болно. Цаашлаад баруун, зүүн аймгуудад нэг нэг нэхий эдлэлийн үйлдвэртэй болох хэрэгтэй юм биш үү. Монголд ямар өвөл болохгүй гэх биш. Гаднаас саримгар куртик оруулж ирж, тэрийг нь бөөнөөрөө авч байхаар нэхий дээлээ өмсөөд явж байвал арай л өөр дөө. Зах зээл нь байна.

Зөвхөн нэхий дээл гэлтгүй өөр олон бүтээгдэхүүн хийж болно. Гуталнаас авахуулаад юу ч хийсэн яах вэ дээ. Манай эмэгтэйчүүд өвөлдөө бойтгон гутал гээд өмсөөд байдаг биз дээ. Дулааныг нь бодоод. Тэр гутлыг өмнөд хөршөөс л оруулж ирдэг. Дотооддоо үйлдвэрлэдэг хэдий ч үнэ жаахан өндөр. Ядаж энэ зах зээлийг бид өөрсдөө эзлээд, гаднаас орох урсгалыг нь татварын бодлогоор зохицуулаад өгчихдөг бол аятай юу. Нэхийгээр хийж болох бүхнийг л хийх хэрэгтэй. Монголд зах зээл багатай гэвэл гадагш нь гаргаж яагаад болохгүй биз. Өвөл болдог орнууд дэлхийгээр л дүүрэн байна.

Энүүхэн хойно байгаа Орос гэж том зах зээл бий. Бид зөв хөдөлж чадвал боломжгүй юм гэж байхгүй. Нэхийгээ хаа хамаагүй өмхийрүүлж, өтүүлж хаяна гэдэг арай л дэндсэн хэрэг. Хаанаас ч хамаагүй, юу л байна зөөж, нэхийгээ хөсөр хаядаг орон байвал яаж хөгжих вэ дээ. Түүний оронд ядаж л нэхийгээрээ бүтээгдэхүүн үйлдвэрлээд, боломжийн үнээр зараад, иргэдийнхээ хэрэгцээг хангадаг орон болчихвол хөгжлийн талаар ярьж болох байлгүй.

# ЧАДВАР” ТЭМЦЭЭН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ЯМАР ТӨВШИНД БАЙГААГ ИЛЭРХИЙЛДЭГ

мэргэжлийн багш томилж, олон улсын тэмцээнд явтал нь тогтмол бэлтгэлд хамруулдаг. Бэлтгэлийн материалд гэхэд маш их мөнгө зарцуулагддаг. Жишээ нь, тогоочийн төрөлд оролцогчийн бэлтгэлийг хангахын тулд далайн загасыг гадаадаас захиалж авчруулдаг. Нэг загас нь 200 мянган төгрөгийн үнэтэй. Хамгийн багадаа дөрвөн ширхэгийг авчруулж байж бэлтгэл нь боломжийн хэмжээнд хангагдсан байна гэж үзнэ. Зөвхөн нэг далайн загасанд 800 мянган төгрөг зарцуулдаг гээд бодохоор мэргэжил тус бүр дээр ямар их хэмжээний зардал гардаг нь та нарт ойлгогдох байх. Германы хамтын ажиллагааны нийгэмлэг хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд тодорхой мэргэжлүүдэд дэмжлэг үзүүлж тусалдаг. Тус нийгэмлэг зарим сургуулиудад герман багш нарыг зөвлөхөөр ажиллуулж байгаа нь МСҮТ, ПК-д суралцагчдад маш их зүйлийг сурч мэдэх боломжийг олгож байна. “Дэлхийн ур чадвар” тэмцээнд оролцогчид өмнө нь Койкагийн шугамаар БНСУ-д бэлтгэл хийж байсан бол энэ удаад ХБНГУ-д бэлтгэл хийж эхэллээ. Сантехникийн төрөлд оролцогч Ц.Долгормаа мэргэжлийн багшийн хамт Германд 21 хоногийн бэлтгэл хийгээд ирсэн. Ирэх сард мужаан, өрөг угсралтын оролцогчид мөн Германд бэлтгэл хангана. Цахилгааны оролцогч энэ сарын сүүлээр Шанхай хотод бэлтгэл хийж байна. Оюутолгой компанийн хувьд гагнуурын мэргэжлийн оролцогчийн бэлтгэлийг Өмнөговьд тогтмол хийлгэж, түүнд тус компанийн гадаад, дотоодын зөвлөх багш нар зааж сургадаг. Эксперт багш нь 2015 онд тэмцээнд орж байсан туршлагатай багш дахин сонгогдсон байгаа.

**-Монгол Улсын баг цаашид энэхүү тэмцээнд улам их амжилттай оролцохын тулд ямар арга хэмжээ авах шаардлагатай гэж үздэг вэ?**

-“Дэлхийн ур чадвар” тэмцээнд амжилттай оролцож байгаа улс орнуудын туршлагаас харахад, оролцогчдоо хамгийн багадаа 2-3 жил, цаашилбал дөрвөн жил тасралтгүй бэлдэж, өдөрт 8-10 цагаар бэлтгэлийг нь хангуулан бэлтгэж байгаа. Энэ нь мэдээж мөнгө санхүү, материаллаг бааз гээд дэмжлэг сайтай байгаатай холбоотой. Манай улсын хувьд энэ боломж нь тааруу байна. Энэ жил хоёрдугаар сард оролцогчдоо тодруулаад, үндсэндээ 6-8 сарын хугацаанд бэлтгэл хийлгүүлээд тэмцээнд оруулах гэж байна. Бэлтгэлийн хугацааг цаашид уртасгах, илүү сайжруулах боломжийг эрэлхийлж ажиллана. Үүнд хэвлэл мэдээллийнхний хувь нэмэр ч чухал шүү дээ.

...Одоохондоо “Дэлхийн ур чадвар” тэмцээнд оролцогчдыг сонгон шалгаруулах зорилгоор дотооддоо тодорхой төрлүүдээр тэмцээн зохион байгуулж байгаа. Цаашид Үндэсний хэмжээнд мэргэжил бүрээр шилдгээ тодруулах тэмцээнийг тогтмол зохион байгуулах, мөн Дэлхийн ур чадварын тэмцээний стандартад дүйцүүлэн зохион байгуулах шаардлагатай байгаа...



**-“Дэлхийн ур чадвар”-т оролцох оролцогчдод зориулсан гурав хоногийн вакум сургалтын талаар уншигчдад мэдээлэл өгөхгүй юу?**

-Олон улсын тэмцээнд оролцогчдод зориулсан анхны вакум сургалтыг хоёр жилийн өмнө Дархан-Уул аймагт зохион байгуулж байсан. 77 орон оролцдог энэхүү нэр хүндтэй тэмцээнд оролцсон аль ч улсын оролцогчид байгаль цаг уур, орчин нөхцөл, үе тэнгийнхнээс нь үзүүлэх нөлөөлөлд автдаг. Олон оролцогчийг харахад, хүүхэд байтугай том хүн хүртэл сүрдэж, сандардаг. Энэ нь тэмцээний амжилтад муугаар нөлөөлдөг. Иймд бид энэхүү тэмцээнд амжилттай оролцохын тулд оролцогч хүүхдүүдээ тэмцээний үеийн болон манлайллын сэтгэл зүй, тухайн тэмцээн болох улсын ёс заншил, харилцааны соёл, сандралыг амьсгалаар яаж тайвшруулж болох бясалгал, иогийн сургалтуудыг хийдэг. Өөрийгөө ялбал өрөөлийг ялна. Өөрийгөө ялах, өөрийн дотоод хүчийг нээхэд чиглэсэн сургалтууд үр нөлөөгөө өгч, тэмцээний амжилтад нөлөөлнө гэдэгт итгэлтэй байна.

**-Энэ жилийн “Дэлхийн ур чадвар” тэмцээн хэдэн сард болох вэ. Хэдэн хүний бүрэлдэхүүнтэй явах вэ?**

-Энэ жил Арабын нэгдсэн Эмират улсын Абу Даби хотод зохиогдох "Дэлхийн ур чадвар"-ын 44 дэхь удаагийн тэмцээн ирэх аравдугаар сарын 14-19-нд болно. Монголын баг зургаан мэргэжлээр, нийт 20 хүний бүрэлдэхүүнтэй явах бэлтгэл хангаж байна.

**-Дэлхийн хэмжээний тэмцээнд оролцож, өрсөлдөж байна гэдэг манай мэргэжлийн боловсрол эзэмшиж буй залуучуудын чадвар улам нэмэгдэж байгаагийн илрэл гэж бодож байна. Дотооддоо иймэрхүү тэмцээн зохион байгуулах боломж хэр их байдаг вэ?**

-Одоохондоо “Дэлхийн ур чадвар” тэмцээнд оролцогчдыг сонгон шалгаруулах зорилгоор дотооддоо тодорхой төрлүүдээр тэмцээн зохион байгуулж байгаа. Цаашид Үндэсний хэмжээнд мэргэжил бүрээр шилдгээ тодруулах тэмцээнийг тогтмол зохион байгуулах, мөн Дэлхийн ур чадварын тэмцээний стандартад дүйцүүлэн зохион байгуулах шаардлагатай байгаа. Тэмцээн зохион байгуулах нь олон талын ач холбогдолтой. Тухайлбал, мэргэжлийн боловсрол эзэмшихээр суралцагчид өөрсдийгөө улам хөгжүүлэх, хосолсон мэргэжил эзэмших, ур чадвараа нэмэгдүүлэх, үнэлүүлэх, зэрэг ахиулах боломж байгаа улмаар ажил олгогчид тэмцээнд оролцогчдоос ажилчдаа сонгон авч болох зэрэг олон давуу талуудыг дурдаж болно. Ингэснээр мэргэжлийн боловсрол эзэмшигчид улам чанаржиж, ажлын байртай болох бас нэг боломж бүрдэнэ.

# ДЭЛХИЙ

## Э.Макроны рейтинг буурсаар байна

Францид явуулсан хамгийн сүүлийн үеийн олон нийтийн санал асуулгаар эдүгээ 39 настай Ерөнхийлөгч Эммануэл Макроныг дэмжигчдийн хувьд өнгөрсөн долдугаар сараас 14-өөр буурч, 40 хувьд хүрчээ. Гэхдээ дэмжигчдийнх нь хувь долдугаар сард ч гэсэн 10 хувиар буурсан үзүүлэлттэй байсан юм. Санал асуулгыг Францын “Ifop” судалгааны компани орон нутгийн “Le Journal du Dimanche” долоо хоног тутмын сэтгүүлтэй хамтран наймдугаар сарын 25-26-ны өдрүүдэд явуулжээ. Санал асуулгад насанд хүрсэн 1023 хүн хамрагдсан байна. “Баруун ч, зүүн ч биш” шинэ төвийн үзэл баримтлалт улс төрийн намын даргаар ажилладаг Э.Макрон сонгогдсоноосоо хойш удирдах арга барил, хэмнэх бодлоготой холбоотойгоор шүүмжлэлд өртөх болжээ. Тэрбээр тавдугаар сарын 7-нд Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулж, Елисейн ордны тэргүүнээр сонгогдсон юм. Тухайн үед түүний дэмжигчдийн хувь харьцангуй өндөр буюу 62 байв. Гэвч, түүнээс хойш гурван сарын дотор 20 гаруй хувиар буурч, 40 болжээ. Энэ үзүүлэлтийг өмнөх Ерөнхийлөгчдийн рейтингтэй ч зарим хэвлэл харьцуулж үзсэн байна. Тодруулбал, Ерөнхийлөгчийн тангаргаа өргөснөөс хойш гурван сарын дараа экс Ерөнхийлөгч Франсуа Олландын дэмжигчдийн хувь 54 /2012 он/, түүний өмнөх Николас Саркозигийнх 67 хувьтай /2007 он/ байсан гэнэ.

## “Самсунг”-ын дэд Ерөнхийлөгч давж заалдах шатны шүүхэд хандлаа



БНСУ-ын экс Ерөнхийлөгч Пак Гын Хэд авлига өгсөн гэх хэргээр шүүхэд дуудагдаж, таван жил хорих ял шийтгүүлсэн “Самсунг Электроникс” компанийн дэд Ерөнхийлөгч 49 настай Ли Жэ Ен давж заалдах шатны шүүхэд хандаж буйгаа өчигдөр мэдэгдлээ. Ли Жэ Енд холбогдох хэргийн шүүх хурал өнгөрөгч баасан гарагт Сөүлийн шүүхэд болсон юм. Гэвч, шүүхийн шийдвэрийг “Самсунг” группын өв залгамжлагч хүлээн зөвшөөрөхгүй байгаа тул ийн давж заалдах шатны шүүхэд хандахаар болжээ. Сөүлийн шүүхийн албан ёсны вэб сайтад Ли Жэ Ений өмгөөлөгч өчигдөр давж заалдах шатны шүүхэд хандсан гэж бичжээ.

Одоогоор үүнээс өөр дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй байна. Ли Жэ Енд прокуророос анх 12 жилийн ял төлөвлөсөн байсан бөгөөд шүүх таван жил болгож бууруулсан аж. Экс ерөнхийлөгч Пак Гын Хэ болон түүний найз Чой Сүүн Сил нарт авлига өгснийхөө хариуд “Самсунг” группын компаниудыг нэгтгэхэд Засгийн газраас дэмжлэг авч, групп доторх эрх мэдлээ нэмэгдүүлэхийг завдсан гэж шүүх үзжээ. Өмнөд Солонгосын хамгийн том бизнес бүлэглэлийн өв залгамжлагч болох Ли Жэ Ён нь Чой хатагтайн удирддаг дөрвөн байгууллагад нийтдээ 38 сая ам.долларын авлига санал болгосон аж. Шүүх хурлын үеэр Ли эдгээр баримтуудыг бүгдийг няцаасан байна.




## НЕФТИЙН ҮНИЙГ ӨСГӨЖ МЭДЭХ НЬ

Б.ДАВАА

АНУ-ын өмнөд этгээдийн Техас мужийг “Харви” хар салхи дайрч, ширүүн бороо үргэлжлэн орсны улмаас бүс нутагт үерийн гамшиг нүүрлэж, хамгийн сүүлд авсан мэдээллээр гурван хүн нас баржээ. Одоо ч ширүүн бороо үргэлжлэн орсоор байгаа бөгөөд мужийн эрх баригчид онц байдал зарлан 3000 цэргийн алба хаагчийг дайчлан гамшгийн бүс рүү илгээж, нүүлгэн шилжүүлэх болон аврах ажиллагааг үргэлжлүүлсээр байна.

Техас мужийг энэ сарын 25-нд “Харви” хар салхи дайрсан юм. Түүнээс хойш цаг агаарын байдал харьцангуй тогтворжсон ч, бороо үргэлжлэн орсны улмаас Техасын Хьюстон зэрэг томоохон хотууд үерт автжээ.

Орон нутгийн агентлагууд бүхэлдээ усаар хүрээлэгдсэн орон сууц, байшингууд болон асрах газартаа өвдгөөр татсан усанд зогсох тэргэнцэртэй настнуудын ахуй байдлыг харуулсан бичлэгийг цацсан юм.

Одоогоор хохирлын хэмжээг тооцох боломжгүй байна. Гэхдээ хамгийн сүүлд авсан мэдээллээр гамшгийн улмаас гурван хүн нас барсан нь тогтоогдсон талаар эх сурвалжууд мэдээлж байгаа юм. АНУ-ын Үндэсний цаг уурын агентлагийн албан ёсны твиттер хуудаст “Урьд нь тохиож байгаагүй гамшиг” хэмээн бичиж, цаашид ч бороо үргэлжлэн орох төлөв ажиглагдаж байгааг анхаарууллаа. Улсад нь томоохон гамшиг нүүрлэсэнтэй холбоотойгоор Ерөнхийлөгч Доналд Трамп ч Техас мужид ажиллахаар болжээ. Тэрбээр өнөөдөр тус мужид очиж, үүссэн нөхцөл байдалтай танилцах юм байна.

Мөн Хьюстон хотын захирагч хэвлэлийнхэнд мэдээлснээр, нэг шөнийн дотор 56 мянга гаруй тусламж хүссэн дуудлага онцгой байдлын албанд ирсэн байна. Энэ тоо цаашдаа ч нэмэгдэж болзошгүй юм байна.

Хамгийн чухал нь АНУ-даа олон тооны газрын тосны байгууламжуудтай, нефт бүтээгдэхүүний өлгий нутаг гэгддэг Техас мужийн эрэг орчимд энэ удаагийн хар салхи, үерийн гамшиг томоохон сөрөг нөлөө учруулж болзошгүй байгааг албаныхан онцолж байгаа юм. Учир нь бороо үргэлжлэн орж, барилга байгууламж усанд автсанаар дээрх газрын тосны байгууламжууд ээлж дараалан тоног төхөөрөмжийн зогсолт хийж эхлээд байна. Тэдний дунд өдөрт 560500 баррел газрын тос олборлодог АНУ-ын газрын тосны салбар дахь хоёр дахь том компани болох “Exxon mobile” үерийн улмаас олборлолтоо зогсоож буйгаа мэдэгдсэн бол мөн өдөрт 325700 баррел нефт олборлодогоороо томоохонд тооцогддог Европын газрын тосны “Royal dutch shell Pic” компани ч ихэнх ажилчдаа аюулгүй бүс нутаг руу нүүлгэн шилжүүлж, үйл ажиллагаагаа зогсоолоо. Тус компанийн тоног төхөөрөмжийн зогсолт нэг долоо хоногийн хугацаагаар үргэлжилж магадгүй байна.

Нөгөө талаар, Техас мужийн нефт олборлогч “Motive enterprises” компани зэрэг зарим газрын тосны үйлдвэрүүд ноцтой хохирол амсаагүй тул үйл ажиллагаагаа үргэлжүүлэхээр төлөвлөж байгаа гэнэ. Гэхдээ томоохон нефт үйлдвэрлэгч компаниуд тоног төхөөрөмжийн зогсолт хийсэн учир цаашдаа газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлт багасч, үнэ нь өсч магадгүй төлөв ажиглагдаж байгааг шинжээчид онцолж байна. Учир нь энэ сарын 27-нд гэхэд Нью-Йоркийн хөрөнгийн биржид баррель нефтийн үнэ хэдэн цагийн хугацаанд савалж, нэг цагийн дотор л зургаан хувиар өсчээ.

Техас мужийн эрэг орчимд, тэр дундаа үерт өртөж ноцтой хохирол амсаад буй Хьюстон хотод АНУ-ын газрын тосны үйлдвэрүүдийн 30 орчим хувь нь байрладаг гэнэ. “lipow oil associates” компанийн Ерөнхийлөгч Эндрю Липов “Энэ бороо Хьюстоны эрчим хүчний дэд бүтцийг бүхэлд нь аюулд оруулах эсэхийг одоогоор хэлж мэдэхгүй байна. Хэрвээ үер ус зайлуулах насосыг усанд автуулах юм бол Техасын үйлдвэрүүд нэг сар хүртэлх хугацаагаар зогсох болно” гэж хэвлэлд ярьсан байна.

Хэрэв гамшгийн улмаас газрын тос олборлогч үйлдвэрүүд тоног төхөөрөмжийн зогсолт хийвэл, эрчим хүчний үнэд өөрчлөлт орж мэдэхээр байна.

# ЭМГЭНЭЛ



**ЦЭРЭНГИЙН ДАМДИНСҮРЭН**
**1955-2017**

Бидний хайрт хань,аав,өвөө,ах,дүү Цэрэн овогтой Дамдинсүрэн нь 2017 оны 08 сарын 27-ны өдөр өвчний улмаас нас нөгчиж, бидний амьдралд нөхөж баршгүй уй гашуу тохиолоо.

Ц.Дамдинсүрэн нь Увс аймгийн Улаангом хотод 1955 хотод төрж, 1963-1973 онд Увс аймгийн Улаангом хотын 10 жилийн нэгдүгээр дунд сургууль, 1973-1974 онд Эрхүү хотын Политехникийн их сургуулийн бэлтгэл анги, 1974-1979 онд МУИС-ийн физик-математикийн факультетийн физикийн салбарыг цөмийн физикч, физикийн багш мэргэжлээр онцсайн дүнтэй суралцаж төгсчээ. 1987 онд Дубна хот дахь Марксизм-Ленинизмийн оройн их сургуулийг мөн амжилттай төгсжээ.

Тэрбээр 1979-1982 онд Ховд аймаг дахь Багшийн дээд сургуульд физикийн багш, 1982-1984 онд физикийн тэнхмийн эрхлэгч, 1985-1992 онд Оросын Холбооны Улсын Дубна хот дахь Цөмийн шинжилгээний нэгдсэн институт (ЦШНИ)-ийн Их энергийн лабораторид эрдэм шинжилгээний ажилтан, ахлах ажилтан, 1992 онд Техникийн их сургуульд физикийн багш, 1993-2008 онд Засгийн газрын Цөмийн энергийн комиссын хариуцлагатай нарийн бичгийн дарга, 2009-2014 онд Засгийн газрын тохируулагч агентлаг Цөмийн энергийн газрын дэд даргаар тус тус ажиллаж байжээ.

Мөн 1974-1979 онд МУИС-ийн Физик-математикийн факультетийн ХЗЭ-ийн хорооны тэргүүлэгч гишүүн, 1979-1982 онд Ховд аймаг дахь Багшийн дээд сургуулийн ХЗЭ-ийн хорооны анхны нарийн бичгийн дарга, 1985-1992 онд Дубна хот дахь монгол ажилтан нарын МАХН-ын үүрийн орлогч дарга зэрэг сонгуульт ажлуудыг гүйцэтгэж байжээ.

Ц.Дамдинсүрэн нь Монголын оюутны анхдугаар чуулга уулзалт, Нийслэлийн МАХН-ын 30 дугаар бага хурал, Шинжлэх ухааны ажилтны улсын зөвлөгөөн, Монголын эдийн засгийн чуулган, “Төрийн албаны шинэтгэл” үндэсний чуулганы төлөөлөгчөөр тус тус ажилаж байсан юм.

Мөн тэрбээр Физик-математикийн шинжлэх ухааны салбарт хэрэгжүүлж байгаа төслүүдэд үнэлгээ өгөх комиссын гишүүн, Физик-математикийн шинжлэх ухааны эрдмийн зэрэг олгох Зөвлөлийн гишүүн, Улсын байнгын онцгой комисссын гишүүн , “Мон-Атом” ХХК-ийн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байжээ.

ЦШНИ-д нам энергийн физикт ашигладаг гамма-спектрометрийн аргаар релятив цөмийн физикийн онолын төсөөллүүдийг шалгах туршлага, судалгааны шинэ ажилд оролцож, их энергитэй протон, нүүрстөрөгчийн ион атомын дунд болон хүнд цөмүүдтэй харилцан үйлчлэхэд их энергийн физикийн факторизац, фрагментацийн зарчмууд мультибарионы системд үйлчилж байгааг харуулжээ. ЦШНИ-д 1990 онд "3.65 ГэВ /нуклон энергитэй протон, нүүрстөрөгчийн ион атомын хүнд цөмүүдтэй харилцан үйлчлэхэд үүсэх үлдэгдэл цөмийн шинж чанарыг судлах нь” сэдвээр физик-математикийн ухааны Дэд докторын зэрэг хамгаалжээ.

Цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг бэхжүүлэх бодлого тодорхойлох, боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулжээ. Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг бэхжүүлэх тухай (2001), Цөмийн энергийн тухай (2009), Цөмийн энергийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль (2009) болон “Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого”-ын төсөл боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх ажилд голлон оролцжээ. Хууль 5, Улсын их хурлын тогтоол 2, Засгийн газрын тогтоол 30 гаруй, Ерөнхий сайдын захирамж 10-ыг гаргах ажлыг биечлэн удирджээ.

Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглахтай холбогдсон эрх зүйн баримт бичиг (2011), Цөмийн энергийн комисс 50 жил (2013), Монгол Улс, ЦШНИ-ийн хоорондын хамтын ажиллагаа (2016) ном болон хэд хэдэн гарын авлага бичин нийт Эрдэм шинжилгээний 40 гаруй бүтээлийг туурвижээ.

Аавын минь ажил хөдөлмөрийг төр засгаас үнэлж Монгол Улсын Эрдмийн зэрэг, цол олгох дээд зөвлөлийн тогтоолоор 1998 онд профессор цол, 2010 онд Ховд их сургуулийн Хүндэт профессор цол тус тус хүртжээ.

Мөн 1980 онд МХЗЭ-ийн ”Хүндэт жуух” бичиг, 1994 онд Боловсрол, шинжлэх ухааны яамны ”Хүндэт жуух” бичиг, 1997 онд “Гэгээрлийн тэргүүний аж илтан” цол, тэмдэг, 1999 онд ”Шинжлэх ухааны тэргүүний ажилтан” цол, тэмдэг, 2001 онд ”Ардын хувьсгалын 80 жил”, ”Боловсролын 80 жил” ойн медаль, 2003 онд ЦШНИ-ийн “Хүндэт үнэмлэх”, 2005 онд “Иргэний хамгаалалтын тэргүүний ажилтан” цол, тэмдэг, 2006 онд төрийн дээд шагнал ”Алтан гадас” одон, 2007 онд Уул уурхайн салбар үүсэж хөгжсөний 85 жилийн “Хүндэт тэмдэг”, 2011онд “Ардын хувьсгалын 90 жил” ойн медаль, Монгол Улсын “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол, тэмдэг, “Юмжаагийн Цэдэнбал” медаль, Хавдар судлалын үндэсний төвийн “Хүндэт тэмдэг”, ШУА-ийн Физик-технологийн хүрээлэнгийн 50 жилийн “Хүндэт тэмдэг”-ээр тус тус шагнагджээ. Мөн волейболын спортын 2-р зэрэгтэй.

Хайрт аавын минь үнэнч шударга,зарчимч,хүнлэг энэрэнгүй,бүтээлч,ажилч хичээнгүй,элдэг даруу зан нь хань, үр хүүхэд,ах дүү,төрөл төрөгсөд бидэндээ үүрд дурсагдах болно.

**Ум сайн амгалан болтугай.**
**Гэр бүл, үр хүүхэд, ах дүү нараас нь**

## Кэндрик Ламар “MTV Video Music Awards 2017”-д тэргүүлэв

Калифорни мужийн Инглвуд хотод хөгжмийн ертөнцөд өнгөрсөн нэг жилийн хугацаанд гарсан хамгийн шилдэг видео клипүүдийг шалгаруулдаг “MTV Video Music Awards 2017” шагнал гардуулах ёслол амжилттай зохион байгуулагдлаа. Уг арга хэмжээг энэ удаад дуучин Кэти Пэрри хөтөлсөн бөгөөд дуучин Ники Минажтай хамтарсан уран бүтээлээ тайзнаа толилуулсан байна.

Энэ удаагийн “MTV Video Music Awards” хөгжмийн наадамд рэппер Кэндрик Ламар зургаан шагнал хүртжээ. Тэрбээр тус шагнал гардуулах ёслолыг өөрийн уран бүтээлээрээ нээсний дараа “Humble” дуугаараа “Шилдэг видео”, “Шилдэг хип хоп”, “Шилдэг уран бүтээлч”, “Шилдэг дүрсний эффект” зэрэг шагналуудыг хүртсэн юм. Английн дуучин, ая зохиогч Эд Шийран наадам дээр рэппер Лил Узи Верттэй хамтарсан уран бүтээлээ толилуулаад зогсохгүй оны шилдэг уран бүтээлч шагналыг хүртсэн бол дуучин Тэйлор Свифт тайзан дээр гараагүй юм.Түүний шүтэн бишрэгчид “Look What You Made Me Do” шинэ дууны клипний анхны үзэгчид болсондоо сэтгэл хангалуун байгаа бөгөөд уг клип “Youtube” видео порталд байршуулснаас нэг цагийн дотор 500 мянган хандалттай болсон юм. Харин дуучин бүсгүй Заян Маликтай дуулсан дуугаараа шилдэг хамтарсан уран бүтээл шагналыг хүртлээ. Энэ үдэш Калифорни мужийн Инглвуд хотод хөгжмийн ертөнцийн бүхий л алдартай одууд хуран цугларчээ. Тухайлбал арга хэмжээний улаан хивсэн дээр дуучин Лорде, Деми Ловато, DJ Халед, Ванесса Хадженс, Пинк, Ники Минаж болон бусад олон уран бүтээлчид хүрэлцэн иржээ.


## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

**2017.08.29**

Баянзүрх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Баянзүрх дүүргийн 12, 15 дугаар хороодод хийгдэх тохижилтын ажлын зураг төсөв боловсруулах-ийг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Баянзүрх дүүргийн 12, 15 дугаар хороодод хийгдэх тохижилтын ажлын зураг төсөв боловсруулах үйлчилгээ болно.

Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг
ирүүлнэ.

**Үүнд:**

-Улсын бүртгэлийн гэрчилгээ /нотариатаар баталгаажуулсан байх./

-Холбогдох зураг төслийн ажлыг гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ /нотариатаар баталгаажуулсан байх./

- Зөвлөхийн дэлгэрэнгүй танилцуулга

- Ижил төрлийн ажил гүйцэтгэж байсан туршлагын талаарх мэдээлэл

- Татварын цахим тайлангийн системээс авсан цахим тодорхойлолт

Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

*Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг авч болох бөгөөд мэдүүлгээ доор дурдсан хаягаар 2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 10.00 цагаас өмнө ифүүлнэ үү.*

**Монгол улс, Улаанбаатар-51**
**Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө-57**
**13 дугаар хороо, Засаг даргын Тамгын газрын байр,**
**1 давхарт 121 тоот, Худалдан авах ажиллагааны алба Утас:70154446**

Сенсаацийн эргэн тойронд

# ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИД АМИА АЛДСААР Л БАЙХ УУ

"Монголын мэдээ" сонин энэ удаагийн "Онцлох хуудас" булангаараа Батлан хамгаалах салбарт өрнөж буй асуудлыг хөндөж байгаа юм. Мэдээж энэ салбарт сайн сайхан зүйлс бишгүй бий. Түүний хажуугаар янз бүрийн шалтгааны улмаас хугацаат цэргийн албан хаагчид амиа алдаж байгаа тохиолдол ч олон гарч байна. Тэр дундаа 2017 он гарсаар олон ноцтой хэрэг гарч, цэргийн албан хаагчид амь нас, эрүүл мэндээрээ хохирч байгаа билээ.

### ГУРВАН ЦЭРЭГ ХОВД ГОЛД ЖИВЖ, АМИА АЛДЛАА

**2017.08.28:** Батлан хамгаалах салбар, тэр дундаа цэргийнхний дунд шүглэсэн чөтгөр арилаагүй л байна. Өчигдөрхөн гурван цэрэг Ховд голд живж амиа алдсан мэдээлэл гарлаа. Энэ талаар хэвлэлүүд "Ховд аймаг дахь Зэвсэгт хүчний 123 ангийн гурван байлдагч өчигдөр Ховд голд осолдож, амь эрсэдсэн байна. Тэдний цогцсыг хайхаар өнөөдөр өглөө 09:00 цагт Онцгой байдлын зургаан аврагч Ховд аймаг руу нисчээ. Хугацаат цэргийн албан хаагчид Увс аймгийн харьяат бөгөөд өнгөрсөн хавар цэрэгт татагдсан юм байна. Тэд Ховд голын эрэг орчимд хадлан хадаж байжээ. Тэгвэл хамт хадлан хадаж буй цэргүүдийн өгсөн мэдээллээр, Ховд гол маш их үертэй байхад усанд орох зөвшөөрлийг ротын дарга нь өгсөн бололтой. Хэргийн талаар холбогдох албаныхан маш их нууцалж байгаа юм байна" хэмээн мэдээлсэн билээ.

### ЭЭЛЖИЙН АХЛАГЧДАА ШИЙТГҮҮЛСЭН ЦЭРЭГ ХӨЛИЙН ЕСӨН ХУРУУГАА ТАЙРУУЛЖЭЭ

**2017.01.17:** Энэ оны эхээр буюу дөрөвдүгээр сард нэгэн цочирдом мэдээлэл гарсан нь цэрэгт алба хааж байсан залууг ээлжийн ахлагч нь дарамталж, хөлийг нь хөлдөөснөөс болж есөн хуруугаа тайруулсан тухай байсан юм. Энэ талаар мэдээллийн сайтууд "2016 оны 5 сард Дорноговь аймгийн Зүүн Баянгийн 336 дугаар ангид цэргийн алба хаахаар явсан Ж.Баярцогтийг 2017 оны нэгдүгээр сарын 17-ны өдөр ээлжийн ахлагч нь өвлийн хүйтэнд шөнийн 2-3 цагийн үед түүнийг болон бусад дөрвөн цэргийн хамтаар дарамталж, нүцгэлэн цээж рүү нь хүйтэн ус цацаж, хүйтэн цементэн дээр хөл нүцгэн зогсоожээ. Үүний улмаас хөл нь хөлдөж, хөлнийхөө 9 хуруугаа тайруулжээ. Эх сурвалжийн мэдээллээр түүнийг шөнийн ээлжинд гарч байхдаа харуулын байранд гал түлж дулаацсан хэмээн буруутгаж, харуулын ахлагч нь шийтгэсэн байна" хэмээн мэдээлж байлаа.

### ЦЭРГЭЭ ЗОДОЖ, ХӨЛИЙН ХУРУУ НЬ ТАС ХӨЛДӨӨСӨН АХЛАГЧИД ЯЛ ОНООЖЭЭ

**2017.06.28:** Дорноговь аймгийн Зүүнбаян дахь Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн ахлагч Э нь цэргүүдээ зодож, биед нь хүнд гэмтэл учруулсан хэргийг шүүх шийдвэрлэжээ. Шүүхээс ахлагч Э-г цэргийн дүрмийн бус байдлаар харьцаж, цэргүүдээ зодож, хүндэвтэр гэмтэл учруулсан гэм буруутайд тооцож 2 жил 6 сарын хорих ялыг жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлэх шийдвэр гаргасан байна. Ахлагч Э нь 2017 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр тус ангийн Хүрээ 1,2 дугаар байгууламжинд харуулын даргын үүрэг гүйцэтгэж байхдаа байлдагч С,Б,Н,Б нартай дүрмийн бус харьцан, нүцгэлэн цээж рүү нь ус цацах, сүмбэ бүсээр ороолгон зодож, хөл нүцгэн гүйлгэн хэрцгий догшин аварласны улмаас байлдагч Б-гийн бие махбодид хүндэвтэр гэмтэл, байлдагч С, Б,Н нарын бие махбодид хөнгөн гэмтэл учруулсан гэмт хэрэгт холбогдсон байдаг.



### ГРАНАТ ДЭЛБЭРЧ, ШИНЭ ЦЭРЭГ ХОЁР ГАРГҮЙ БОЛЖЭЭ

**2017.02.15:** 2017 он гарахтай зэрэгцээд л батлан хамгаалах салбарт, тэр дундаа цэргийн ангиудад янз бүрийн хэрэг гарч эхэлсэн. Тэр дундаа гранат дэлбэрсэн хэрэг гарсан юм. Энэ талаар мэдээллийн сайтууд "Зэвсэгт хүчний 186 дугаар ангид гранат дэлбэрч, улмаар цэрэг хүнд бэртсэн хэрэг гарчээ. Тодруулбал, тус цэргийн ангид өнгөрсөн хавар татагдан очсон шинэ цэрэг гранат цэвэрлэж байтал дэлбэрсэн байна. Дэлбэрэлтийн улмаас түүний хоёр нүд хараагүй болж, хоёр гараа тайруулсан аж. Одоогоор түүний биеийн байдал хүнд байгаа хэмээн эх сурвалж мэдээллээ. Зэвсэгт хүчний 186 дугаар анги нь Эрдэнэт хотод байрладаг бөгөөд 80 гаруй жилийн түүхтэй юм" хэмээн мэдээлж байлаа.

### АМИА АЛДСАН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫН АНГИЙН ЗАХИРАГЧИЙГ АЖЛААС НЬ ЧӨЛӨӨЛЖЭЭ

**2017.04.24:** Гранат дэлбэрсэн хэрэгтэй холбоотойгоор ангийн захирагчид хариуцлага тооцсон. Энэ талаар мэдээллийн хэрэгслүүд "Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн офицер, ахлагч хоёр гар бөмбөгийн дэлбэрэлтэд өртөн амиа алдаж, найман ахлагч шархадсан хэрэг энэ сарын 11-нд гарсан билээ. Уг осолтой холбоотойгоор Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэ ЗХЖШ-ын дэслэгч генерал Д.Даваад "Цэргийн хоёр алба хаагч амь үрэгдсэн ноцтой хэрэгт шууд хамаарал бүхий ажил хариуцсан албан тушаалтнуудад холбогдох хуулийн дагуу хатуу хариуцлага тооцож, дөрөвдүгээр сарын 21-ний дотор илтгэх" үүрэг өгсөн. Тэгвэл энэ сарын 21-ний өдөр ЗХЖШ-ын даргын зөвлөл хуралдаж, Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн захирагч, хурандаа Д.Өлзийбаярыг үүрэгт ажлаас нь чөлөөлжээ" хэмээн мэдээлж байлаа.

### Ж.БАДАМБАЗАР: БИД ХАРИУЦЛАГАА ҮҮРЭХЭД БЭЛЭН

**2017.04.12:** Зэвсэгт хүчний жанжин штабын орлогч дарга, хошууч генерал Ж.Бадамбазар тэргүүтэй хүмүүс хэрэг гарсны дараахан мэдээлэл хийж, хариуцлагаа үүрэхэд бэлэн байгаагаа мэдэгдсэн. Тэрбээр "Бэлтгэлийг амь эрсэдсэн алба хаагч ахмад Б.Мөнгөншагай өөрөө ахалж, удирдан явуулж байсан. Хээрийн сургуулилалтын үеэр гранат шидэх бэлтгэлээ хангах үед дэлбэрэлт болсон. Төв аймгийн цагдаагийн хэлтэс болон хууль хяналтын байгууллагаас шалгаж байна. Үнэхээр гранатыг өөрсдөө алдсан уу, эсвэл хөндлөнгийн хүн оролцсон уу гэдгийг хуулийн байгууллага тогтооно. Хууль хяналтын байгууллага ослын шалтгааныг тогтоовол бид хариуцлах хүлээнхэд бэлэн байна. Ямар шалтгаан байсныг бид хэлж мэдэхгүй. Тиймээс цагдаагийн байгууллага эцэслэн тогтооно" хэмээн ярьсан билээ.

### ТАВАНТОЛГОЙД ГРАНАТ ДЭЛБЭРЧ, ХОЁР ЦЭРЭГ АМИА АЛДЛАА

**2017.04.11:** Гранат дэлбэрсэн нэг хэргийн асуудал замхраагүй байхад дахиад гарав. Тэгэхдээ бүр хоёрын хоёр албан хаагчийн амь нас хохирсон юм. Энэ талаар мэдээллийн хэрэгслүүд "Төв аймгийн нутаг дэвсгэрт байрлах зэвсэгт хүчний хээрийн сургалтын төв болох Тавантолгойд гранат дэлбэрч, хоёр цэрэг амиа алдаж, найман цэрэг шархадсан харамсалтай хэрэг гарчээ. Саяхан Цэргийн төв госпиталаас эмнэлэгийн баг ослын газрыг зорьсон байна. Эх сурвалжийн хэлж буйгаар амиа алдсан цэргүүд Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн албан хаагчид байжээ. Уг хэрэг өнөөдөр 18:00 цагийн орчимд гарсан бөгөөд тэд хээрийн сургуулилтын бэлтгэлд гарч байгаад осолд орсон нь энэ аж" хэмээн мэдээлж байлаа.

Сэтгүүлчийн өнцөг

# ОДОО Б.БАТ-ЭРДЭНЭ САЙД ОГЦРОХ БАЙЛГҮЙ ДЭЭ

Н.ПУНЦАГБОЛД

Зэвсэгт хүчний тэддүгээр ангид тийм ч хэрэг боллоо, ингэж ч цэрэг бэртлээ, эрүүл мэндээрээ хохирлоо. Дарга нар нь байлдагчаа дарамталж, хөл гарыг нь хөлдөөлөө. Амиа хорлоход хүргэлээ. Энэ мэдээллийг бид хэчнээн ч жил сонсч байна даа. Яах вэ, сүүлийн жилүүдэд цэргийн албанд очиход дарга нар нь дарамтлаад, зодож нүдээд байх явдал арилсан гээд байгаа. Нэг үеэ бодвол Монгол Улс хүний эрхийг дээдэлдэг болсон. Эцэг, эхчүүд ч үр хүүхдийнхээ араас санаа тавьж, цэрэгт очоод бэртэж гэмтэж, эрүүл мэндээрээ хохирвол гомдол нэхэж, хариуцлага шаарддаг болчихоод байгаа. Тиймдээ ч цэргийн дарамт багассан. Гэхдээ л огт алга болчихоогүй байгааг цөөнгүй жишээ харуулж байна.

Байлдагчаа өвлийн хүйтэнд цементэн шалан дээр зогсооно гэдэг чинь одоо балиар дарамт биш үү. Нэг сайхан залуу хөлгүй болоод, насаараа тахир дутуу үлдэж байна. Эх орныхоо төлөө цэргийн албанд татагдаад шүү дээ. Гомдолтой л хэрэг. Дээрээс нь хээрийн сургуулилтын үеэр гранат дэлбэрч байх жишээтэй. Шинэ цэргээр гранат цэвэрлүүлж байгаад өнөөх нь дэлбэрээд л. Байлдагч шинээр очиж байхад гранат цэвэрлүүлнэ гэж юу ч гэсэн үг юм. Сонирхолтой байгаа биз дээ. Одоо бүр сүүлдээ цэргүүд голд живж амиа алдаж байна. Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн байлдагчид. Гурвуулаа Увс аймгаас очиж алба хааж байсан юм билээ. Өмнө нь ч энэ ангид нэг байлдагч амиа хорлож байсан удаатай. 2013 онд. Ер нь баруун аймгуудад байрлах цэргийн ангиудад үе үе хэцүүхэн хэрэг гардаг. Хөвсгөлийн хэдэн цэрэг яасан билээ. Эцэг, эх нь өчнөөн гомдол нэхэж явсан ч Монголын төр тоогоогүй. Батлан хамгаалах салбар нэг иймэрхүү л байна.

Гэтэл салбарын сайд Б.Бат-Эрдэнэ өнөөдрийг хүртэл зөөлөн суудалдаа заларсаар л. Уг нь өнгөрсөн дөрөвдүгээр сард эрхэм сайдыг огцруулах саналыг хүргүүлж байсан. Гэвч түүнд хариуцлага тооцоогүй. Уг нь салбарынхаа болж бүтэхгүй болгоныг засч, залруулахын төлөө чөмгөө дундартал ажиллах ёстой биз дээ. Чадахгүй бол ёс зүйтэйхэн шиг ажлаа өгөх л ёстой. Хэдэн цэрэг санаандгүй байдлаар усанд осолдсоны төлөө сүржигнэлээ гэж зарим нь өмөөрч магадгүй. Зөвхөн 2017 онд ямар ямар хэрэг гарав. Юу, юу болов гэдгийг л эргээд нэг харчих. Ноцтой гэснийг нь дээр дурьдлаа. Үүнээс гадна гарсан хэрэг алийг тэр гэхэв. МАН Боловсролын сайдаа шалгалтын материал задарснаас болоод огцруулаа биз дээ. Тэгвэл Батлан хамгаалах салбарт олон үйл явдал өрнөж, цөөнгүй цэрэг амиа алдчихлаа. Шалгалтын материал задрахаас л дор байв гэж.

Тийм болохоор сайдтан өөрийнхөө хүсэлтээр огцорчихсон нь нэр хүндтэй биш үү. Тэгээд цаашид цэргийн ангиуд, тэр дундаа алслагдсан аймаг, орон нутагт байрладаг Зэвсэгт хүчний анги нэгтгэлийг маш сайн хянаж байх хэрэгтэй байна. Хэдий болтол бид энх цагт улс орны ирээдүй болсон залуучуудынхаа амь насыг эрсдүүлсээр байх юм бэ. Хэдий болтол олон сайхан аавын хөвгүүд ааш нь эвдэрсэн дарга, захирагчийн дарамтаас бол эрүүл мэндээрээ хохирч байх ёстой гэж. Цэрэгт очсон залуучуудыг цэцэрлэгийн хүүхэд шиг бөөцийл гээгүй. Тэд бэлтгэл сургуулилт хийгээд, цэргийн зохих мэдлэгтэй болох ёстой. Бие бялдрын хувьд чийрэгжиж, үзэл бодол төлөвших хэрэгтэй. Жинхэнэ эр хүн болох ёстой юу гэвэл тийм. Гэхдээ сургаж, хүмүүжүүл, чийрэгжүүл гэж цэрэгт явуулдаг болохоор хөлийг нь хөлдөө, өвлийн хүйтэнд дэглэ гэж явуулдаггүй л байх шүү. Үүнийг ч салбарын сайд нь мэдэж байгаа байлгүй. Нэг хэрэг болохоор л дунд шатны хэдэн хүний ажлыг "булаагаад", өөрөө ард нь үлдээд байх муурхай биш үү. Тэдэндээ ч хариуцлагаа тооц, өөрөө ч бас үүрэлцэх хэрэгтэй байх аа.

# МЭДЭЭЛЭЛ

## АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДЫН АНХААРАЛД

Доорх жагсаалтад нэр дурдсан тусгай зөвшөөрөл эзэмшигчид Та бүхэн хүснэгтэд заасан хугацаанд Ашигт малтмалын тухай хуулийн 32 дугаар зүйл болон 34 дүгээр зүйлийн 34.4-д заасны дагуу төлбөрөө хугацаанд нь бүрэн төлж бүртгүүлэхийг мэдэгдье.

| № | Код | Эзэмшигч | Талбай (га) | Олгосон огноо | Дуусах огноо |
|---|---|---|---|---|---|
| 1 | XV-014088 | Мизү | 1601,03 | 2008.09.01 | 2017.09.01 |
| 2 | XV-014089 | Мизү | 8586,12 | 2008.09.01 | 2017.09.01 |
| 3 | MV-010380 | Говьгео | 29,42 | 2005.09.01 | 2035.09.01 |
| 4 | XV-014084 | ДБТХ | 672,56 | 2008.09.01 | 2017.09.01 |
| 5 | MV-004822 | Алтандорнод монгол | 114,46 | 2002.09.02 | 2032.09.02 |
| 6 | XV-014092 | Хадат өндрийн өгөөж | 159,11 | 2008.09.02 | 2017.09.02 |
| 7 | MV-016982 | Хонгорын орд | 84,49 | 2002.09.02 | 2032.09.02 |
| 8 | XV-020586 | Эм Эн Эм | 936,93 | 2015.09.02 | 2018.09.02 |
| 9 | XV-018555 | СННС | 5488,36 | 2015.09.02 | 2018.09.02 |
| 10 | XV-020212 | Монголианхээдвэй | 3489,72 | 2016.09.02 | 2019.09.02 |
| 11 | MV-019137 | Монгол чадал интернэшнл энержи | 1110,49 | 2015.09.03 | 2045.09.03 |
| 12 | MV-015100 | Амирлангуй-Үжин | 404,98 | 2009.09.03 | 2039.09.03 |
| 13 | XV-015099 | Алтарганахайрхан | 14835,42 | 2009.09.03 | 2018.09.03 |
| 14 | XV-017881 | Ресурс партнерс групп | 1798,08 | 2015.09.03 | 2018.09.03 |
| 15 | MV-017378 | Гоулдсэнын монголиа | 199,29 | 2013.09.03 | 2043.09.03 |
| 16 | MV-011981 | Цагаан-Элгэн | 30,11 | 2006.09.04 | 2036.09.04 |
| 17 | MV-012680 | Ёнченг | 6,17 | 2007.09.04 | 2037.09.04 |
| 18 | MV-011979 | Монгол-Анар трейд | 376,08 | 2006.09.04 | 2036.09.04 |
| 19 | XV-015114 | Мочистоун | 1470,54 | 2009.09.04 | 2018.09.04 |
| 20 | XV-015112 | Жорчидай | 943,95 | 2009.09.04 | 2018.09.04 |
| 21 | XV-014108 | Топазстоне майнинг | 69950,73 | 2008.09.04 | 2020.09.04 |
| 22 | XV-014105 | Сауд гоби блейк гоулд | 651,27 | 2008.09.04 | 2020.09.04 |
| 23 | MV-017604 | Туншан шиандон | 42,12 | 2014.09.05 | 2044.09.05 |
| 24 | XV-011987 | Өгөөмөр-Алт | 2866,34 | 2006.09.05 | 2018.09.05 |
| 25 | XV-011990 | Монлаа | 4128,05 | 2006.09.05 | 2018.09.05 |
| 26 | MV-017120 | Тайшэн девелопмент | 907,49 | 2012.09.06 | 2042.09.06 |
| 27 | MV-004852 | Спот констракшн | 29,43 | 2002.09.06 | 2032.09.05 |
| 28 | MV-017121 | Мандал-Алтай групп | 53,63 | 2012.09.06 | 2042.09.06 |
| 29 | XV-012685 | Алкалли метал монголиа | 12410,94 | 2007.09.06 | 2018.09.06 |
| 30 | MV-017117 | Эн Си Жи Ти | 321,71 | 2012.09.07 | 2042.09.07 |
| 31 | MV-017430 | Эй Эйч Жи металлс групп | 713,12 | 2011.09.07 | 2041.09.07 |
| 32 | MV-017118 | Майпло майнинг девелопмент | 450,56 | 2012.09.07 | 2042.09.07 |
| 33 | MV-019149 | Энхтунх орчлон | 6664,61 | 2015.09.08 | 2045.09.08 |
| 34 | MV-014112 | Чин | 277,54 | 2008.09.08 | 2038.09.08 |
| 35 | MV-015651 | Оргил моунт | 870,59 | 2010.09.08 | 2040.09.08 |
| 36 | MV-000287 | Таван толгойн нүүрсний уурхай | 276,91 | 1995.09.08 | 2025.09.08 |
| 37 | MV-020624 | Оргил моунт | 254,32 | 2010.09.08 | 2040.09.08 |
| 38 | XV-018406 | Эм Би Би Си | 11216,36 | 2015.09.08 | 2018.09.08 |
| 39 | XV-018090 | Платинумланд | 2184,44 | 2015.09.08 | 2018.09.08 |
| 40 | XV-018951 | Бумбат голд | 2696,7 | 2015.09.08 | 2018.09.08 |
| 41 | XV-014140 | ЦЕТ | 59,03 | 2008.09.09 | 2020.09.09 |
| 42 | MV-015119 | Бужгар-Орд | 379,25 | 2009.09.09 | 2039.09.09 |
| 43 | MV-017027 | МГМК | 64,04 | 2008.09.09 | 2038.09.09 |
| 44 | XV-008323 | Монголцамхаг | 1418,42 | 2004.09.09 | 2013.09.09 |
| 45 | MV-012630 | Эрдэнэсмайнинг | 116,45 | 2007.08.10 | 2037.09.09 |
| 46 | XV-014139 | ЦЕТ | 135,39 | 2008.09.09 | 2020.09.09 |
| 47 | XV-014132 | Топазстоне майнинг | 5040,98 | 2008.09.09 | 2020.09.09 |
| 48 | XV-014126 | Шинэлонгда | 9245,88 | 2008.09.09 | 2020.09.09 |
| 49 | XV-014138 | Болоргол | 85,79 | 2008.09.09 | 2017.09.09 |
| 50 | XV-017597 | Болоргол | 41,85 | 2008.09.09 | 2017.09.09 |
| 51 | MV-016653 | Улз гол | 657,97 | 2010.09.09 | 2040.09.09 |
| 52 | MV-019187 | Салхит майнинг | 1334,28 | 2015.09.09 | 2045.09.09 |
| 53 | MV-020417 | Минюу шиши | 97,24 | 2009.09.09 | 2039.09.09 |
| 54 | XV-014145 | Элбэг-орд | 8397,73 | 2008.09.10 | 2017.09.10 |
| 55 | MV-015124 | Нэйчө | 523,64 | 2009.09.10 | 2039.09.10 |
| 56 | XV-017016 | Дөрвөнхүмүүн | 962,06 | 2006.10.25 | 2018.09.10 |
| 57 | XV-014148 | Ихтүмэн бээр | 39,55 | 2008.09.11 | 2020.09.11 |
| 58 | MV-019225 | Фэско | 53,85 | 2015.09.11 | 2045.09.11 |
| 59 | MV-014147 | Эрдэнэдорно | 228,81 | 2008.09.11 | 2038.09.11 |
| 60 | XV-012692 | Говьхурах | 5441,31 | 2007.09.11 | 2019.09.11 |
| 61 | XV-015132 | Пакимор | 3694,2 | 2009.09.11 | 2018.09.11 |
| 62 | XV-014152 | Дүүлэх шонхор | 8136,56 | 2008.09.11 | 2020.09.11 |
| 63 | XV-012702 | Афро азия минералз | 25640,31 | 2007.09.11 | 2019.09.11 |
| 64 | MV-017610 | Монсөнөд | 37,36 | 2014.09.11 | 2044.09.11 |
| 65 | MV-017609 | Блэкпланет | 245,7 | 2014.09.11 | 2044.09.11 |
| 66 | XV-014156 | Рэдхилмонголия | 7385,23 | 2008.09.11 | 2017.09.11 |
| 67 | MV-012700 | Төгс-Эхлэл | 53,16 | 2007.09.11 | 2037.09.11 |
| 68 | MV-017129 | Вантаже | 5757,04 | 2012.09.12 | 2042.09.12 |
| 69 | XV-012703 | Уэлт-Эксплорэйшн | 3223,41 | 2007.09.12 | 2019.09.12 |
| 70 | MV-017131 | Монлаа | 585,55 | 2012.09.12 | 2042.09.12 |
| 71 | XV-012704 | Трежур-Эксплорэйшн | 4648,52 | 2007.09.12 | 2019.09.12 |
| 72 | XV-012705 | Империал метал групп | 5270,88 | 2007.09.12 | 2019.09.12 |
| 73 | MV-010423 | Жиншентан | 15,94 | 2005.09.12 | 2035.09.12 |
| 74 | XV-012707 | Тройгоби | 3663,2 | 2007.09.12 | 2019.09.12 |
| 75 | MV-004872 | Дорнын нүүрс | 81,49 | 2002.09.13 | 2032.09.13 |
| 76 | XV-018573 | Баялаг эрдэс цогт | 4056,75 | 2016.09.13 | 2019.09.13 |
| 77 | XV-012712 | Урагшлахговь | 2100,55 | 2007.09.13 | 2019.09.13 |
| 78 | MV-010434 | Монголруд пром | 41,7 | 2005.09.14 | 2035.09.14 |
| 79 | MV-019233 | Мийдлгоби майнинг | 2910,51 | 2015.09.14 | 2045.09.14 |
| 80 | MV-017036 | Восточный дорог | 122,48 | 2005.09.14 | 2035.09.14 |
| 81 | XV-002602 | Эрдэнэт-Үйлдвэр | 37840,85 | 2000.09.15 | 2016.09.15 |
| 82 | XV-018980 | Цахирт өндөр майнинг | 4255,47 | 2015.09.15 | 2018.09.15 |
| 83 | XV-012730 | Лхагважин | 7240,29 | 2007.09.24 | 2020.09.15 |
| 84 | MV-016658 | Болоршүр | 345,46 | 2010.09.16 | 2040.09.16 |
| 85 | XV-015140 | Эмэмарай | 144,17 | 2009.09.16 | 2018.09.16 |
| 86 | MV-017384 | Эм Ди Эф И | 2057,36 | 2013.09.16 | 2043.09.16 |
| 87 | XV-014162 | Саруул сансар | 3771,56 | 2008.09.16 | 2017.09.16 |
| 88 | XV-006325 | Адамасмайнинг | 6262,92 | 2003.09.17 | 2012.09.17 |
| 89 | MV-001865 | Үүрттур | 227,34 | 1999.09.17 | 2029.09.17 |
| 90 | MV-019327 | Өнт-Өнгөт | 1701,64 | 2015.09.18 | 2045.09.18 |
| 91 | XV-012720 | Топазстоне майнинг | 162,7 | 2007.09.18 | 2019.09.18 |
| 92 | MV-012721 | Алтайконстракшн | 72,29 | 2007.09.18 | 2037.09.18 |
| 93 | MV-019328 | Түшээговь | 1967,96 | 2015.09.18 | 2045.09.18 |
| 94 | XV-016677 | Говьшоо | 100,42 | 2007.09.18 | 2019.09.18 |
| 95 | XV-018418 | Стархолдинг | 6694,78 | 2015.09.18 | 2018.09.18 |
| 96 | XV-018391 | Цогш | 740,52 | 2015.09.18 | 2018.09.18 |
| 97 | MV-017100 | Авдарбаян | 28,44 | 2002.09.19 | 2032.09.19 |
| 98 | MV-017408 | Мондулаан трейд | 313,79 | 2006.09.19 | 2036.09.19 |
| 99 | MV-017611 | Олгойбулаг | 470,82 | 2014.09.19 | 2044.09.19 |
| 100 | MV-010457 | Бриджконстракшн | 32,17 | 2005.09.19 | 2035.09.19 |
| 101 | MV-012039 | Бороогоулд | 910,57 | 2006.09.19 | 2036.09.19 |
| 102 | XV-012028 | Цэвдэг | 610,25 | 2006.09.19 | 2018.09.19 |
| 103 | MV-012029 | Цэвдэг | 139,05 | 2006.09.19 | 2036.09.19 |
| 104 | MV-012031 | Ирвэс-интертрейд | 451 | 2006.09.19 | 2036.09.19 |
| 105 | MV-017035 | Восточный дорог | 25,33 | 2007.09.20 | 2037.09.20 |
| 106 | MV-020628 | Форс голд майнинг | 1639,24 | 2016.09.20 | 2046.09.20 |
| 107 | MV-020629 | Гурвансайхан | 4628,42 | 2016.09.20 | 2046.09.20 |
| 108 | MV-010483 | Хунхуа | 24,31 | 2005.09.20 | 2035.09.20 |
| 109 | MV-012726 | Саусгоби сэндс | 9282,76 | 2007.09.20 | 2037.09.20 |
| 110 | MV-010488 | Гоал тоавард майнинг | 50,2 | 2005.09.20 | 2035.09.20 |
| 111 | MV-020633 | Гурвансайхан | 10386,24 | 2016.09.20 | 2046.09.20 |
| 112 | MV-010489 | Бат-Адар | 30,95 | 2005.09.20 | 2035.09.20 |
| 113 | XV-010484 | Хонгорхангай эрдэнэс | 2483,06 | 2005.09.20 | 2017.09.20 |
| 114 | MV-020634 | Гурвансайхан | 10665,22 | 2016.09.20 | 2046.09.20 |
| 115 | MV-020631 | Гурвансайхан | 2810,44 | 2016.09.20 | 2046.09.20 |
| 116 | XV-015148 | Ньюмандшир | 7120,27 | 2009.09.21 | 2018.09.21 |
| 117 | MV-012728 | Гобикоул энд энержи | 490,15 | 2007.09.21 | 2037.09.21 |
| 118 | MV-019329 | Монголиан Лантаноиде Корпораци | 106,66 | 2015.09.21 | 2045.09.21 |
| 119 | MV-019330 | Хан Алтайн тоосго | 25,94 | 2015.09.21 | 2045.09.21 |
| 120 | XV-018666 | Оргилттэмүүлэл | 2287,91 | 2015.09.21 | 2018.09.21 |
| 121 | MV-016660 | Зэст-Өндөр | 583,83 | 2010.09.21 | 2040.09.21 |
| 122 | MV-020637 | Буман-Олз | 2521,63 | 2016.09.22 | 2046.09.22 |
| 123 | MV-016662 | Ди Эйч Пи Эн | 28,34 | 2010.09.22 | 2040.09.22 |
| 124 | XV-017145 | Эс Пи Жи | 1441,27 | 2008.09.22 | 2020.09.22 |
| 125 | MV-010508 | Шандын нуруу | 257,17 | 2005.09.22 | 2035.09.22 |
| 126 | XV-014177 | Хонгорхангай эрдэнэс | 69878,08 | 2008.09.22 | 2017.09.22 |
| 127 | MV-002613 | Гөүлдэннэст | 25,75 | 2000.09.22 | 2030.09.22 |
| 128 | MV-020636 | Мегатек манюфактуринг монголиа | 203,86 | 2016.09.22 | 2046.09.22 |
| 129 | XV-014192 | Ньютиара | 6718,07 | 2008.09.23 | 2020.09.23 |
| 130 | MV-008469 | Хөхтөр | 76,08 | 2004.09.23 | 2034.09.23 |
| 131 | XV-014193 | Цахирцагаан гол | 511,99 | 2008.09.23 | 2017.09.23 |
| 132 | MV-015151 | Жи Би Эм | 78,67 | 2009.09.23 | 2039.09.23 |
| 133 | MV-014196 | Дримлэйнд | 353,54 | 2008.09.23 | 2038.09.23 |
| 134 | MV-008468 | Хөхтөр | 74,98 | 2004.09.23 | 2034.09.23 |
| 135 | MV-010511 | Ирмүүнзээрд | 1189,19 | 2005.09.23 | 2035.09.23 |
| 136 | XV-014195 | Ялгуун-Интернэйшнл | 107,55 | 2008.09.23 | 2017.09.23 |
| 137 | XV-018450 | Мөнхбичигт | 6945,72 | 2015.09.24 | 2018.09.24 |
| 138 | XV-014201 | Нутгийн гантиг | 507,13 | 2008.09.24 | 2017.09.24 |
| 139 | MV-015161 | Ловонко | 397,93 | 2009.09.24 | 2039.09.24 |
| 140 | MV-019331 | Космо коал | 5488,42 | 2015.09.24 | 2045.09.24 |
| 141 | XV-012731 | МН ба ахас | 1669,84 | 2007.09.24 | 2019.09.24 |
| 142 | XV-017748 | Их сүү | 6877,32 | 2015.09.24 | 2018.09.24 |
| 143 | MV-011824 | Топруонхэнцо | 53,44 | 2001.09.24 | 2031.09.24 |
| 144 | MV-017615 | Жи Эф Си | 378,13 | 2014.09.24 | 2044.09.24 |
| 145 | MV-017616 | Илчлэгхайлан | 39,33 | 2014.09.24 | 2044.09.24 |
| 146 | MV-017386 | Бэствайт | 103,86 | 2013.09.24 | 2043.09.24 |
| 147 | XV-018258 | Улиастайчулуу | 4864,01 | 2015.09.24 | 2018.09.24 |
| 148 | XV-012055 | Бэрхресорсиз | 2749,85 | 2006.09.25 | 2018.09.25 |
| 149 | XV-015162 | Иххаан чулуу | 1407,59 | 2009.09.25 | 2018.09.25 |
| 150 | XV-018362 | Хасбагана | 441,06 | 2015.09.25 | 2018.09.25 |
| 151 | XV-018981 | Говийн нар транс | 2120,55 | 2015.09.25 | 2018.09.25 |
| 152 | MV-001356 | Хорих 443-р анги | 82,8 | 1998.09.25 | 2028.09.25 |
| 153 | MV-012056 | Ордталст | 92,8 | 2006.09.25 | 2036.09.25 |
| 154 | MV-012049 | Гуравт | 49,57 | 2006.09.25 | 2036.09.25 |
| 155 | XV-012053 | Бэрхресорсиз | 3682,72 | 2006.09.25 | 2018.09.25 |
| 156 | XV-018229 | Бугалуудконсалтинг | 256,98 | 2015.09.25 | 2018.09.25 |
| 157 | XV-014552 | Сутайнтэргүүн | 33,43 | 2008.12.08 | 2018.09.25 |
| 158 | XV-019772 | Ковертдайлинг майнинг | 996,99 | 2016.09.26 | 2019.09.26 |
| 159 | XV-014211 | Илчлэгхайлан | 50,72 | 2008.09.26 | 2017.09.26 |
| 160 | XV-015591 | Центрвилл | 2785,51 | 2007.09.26 | 2019.09.26 |
| 161 | MV-014209 | Энгүйтал | 692,42 | 2008.09.26 | 2038.09.26 |
| 162 | MV-017389 | Минтекминералс | 683,61 | 2013.09.27 | 2043.09.27 |
| 163 | MV-020638 | Хасгуа | 26,46 | 2016.09.27 | 2046.09.27 |
| 164 | XV-012743 | Боролзой | 547,94 | 2007.09.27 | 2019.09.27 |
| 165 | MV-012756 | Си Эф Си групп | 25,73 | 2007.09.27 | 2037.09.27 |
| 166 | XV-008488 | Некстмайн | 3273,91 | 2004.09.27 | 2016.09.27 |
| 167 | MV-008478 | Гацуурт | 120,83 | 2004.09.27 | 2034.09.27 |
| 168 | MV-016664 | Сэлмандал | 135,02 | 2010.09.27 | 2040.09.27 |
| 169 | MV-017387 | Оюут-Улаан | 6647,05 | 2013.09.27 | 2043.09.27 |
| 170 | MV-017388 | Си Би Жи Эм | 319,72 | 2013.09.27 | 2043.09.27 |
| 171 | MV-008479 | Гацуурт | 588,21 | 2004.09.27 | 2034.09.27 |
| 172 | XV-012759 | Наранбулаг шим | 3173,5 | 2007.09.27 | 2019.09.27 |
| 173 | XV-019013 | Нүүрс хими | 2394,47 | 2015.09.28 | 2018.09.28 |
| 174 | XV-018918 | Талын Монгол Групп | 30464,01 | 2015.09.28 | 2018.09.28 |
| 175 | MV-016669 | Түмэн-Анд | 154,46 | 2010.09.28 | 2040.09.28 |
| 176 | MV-016668 | Түмэн-Анд | 451,25 | 2010.09.28 | 2040.09.28 |
| 177 | XV-019009 | СБЭБ | 1820,32 | 2015.09.28 | 2018.09.28 |
| 178 | MV-016920 | Түмэнцацал | 31,98 | 2010.09.28 | 2040.09.28 |
| 179 | XV-018924 | Талын Монгол Групп | 5009,66 | 2015.09.28 | 2018.09.28 |
| 180 | MV-010551 | Бэрэнгрупп | 565,47 | 2005.09.29 | 2035.09.29 |
| 181 | XV-014219 | Нью-Орем | 1237,17 | 2008.09.29 | 2017.09.29 |
| 182 | XV-017600 | АЭР зам | 87,29 | 2005.09.29 | 2017.09.29 |
| 183 | MV-014218 | Засаг сүмбэр | 59,44 | 2008.09.29 | 2038.09.29 |
| 184 | MV-017617 | Майнтөмөр | 713,16 | 2014.09.29 | 2044.09.29 |
| 185 | XV-012075 | Мартин майнинг | 185,92 | 2006.09.29 | 2018.09.29 |
| 186 | XV-015167 | Голден гроуз айбекс | 3272,7 | 2009.09.30 | 2018.09.30 |
| 187 | XV-014231 | Баян өлзийт болд | 109,17 | 2008.09.30 | 2017.09.30 |
| 188 | MV-000270 | Эрдэсналайх | 0,54 | 1995.09.30 | 2025.09.30 |
| 189 | MV-015170 | Шинэсансар | 1684,89 | 2009.09.30 | 2039.09.30 |
| 190 | MV-015169 | Гаррисон-Ази | 469,83 | 2009.09.30 | 2039.09.30 |
| 191 | MV-006364 | Нарийн гол гоулд | 364,88 | 2003.09.30 | 2033.09.30 |
| 192 | XV-018441 | Маунт шаста | 6287,32 | 2015.09.30 | 2018.09.30 |
| 193 | XV-018474 | Юү И Ар Ти Си Эф Жи | 3223,5 | 2015.09.30 | 2018.09.30 |
| 194 | MV-017392 | Идэрголд | 565,86 | 2013.09.30 | 2043.09.30 |
| 195 | XV-014999 | Эм Жи Эм Жи | 2607,67 | 2008.09.30 | 2017.09.30 |
| 196 | MV-014228 | Илчитметалл | 65,54 | 2008.09.30 | 2038.09.30 |
| 197 | MV-016922 | Кайлонкуонеэ | 250,76 | 2011.09.30 | 2041.09.30 |

1 Та тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрөө дараах дансанд тушаана уу.
Төрийн сан банк 100900000712 /Төгрөгийн/
2 Та холбогдох мэдээллээ http://mram.gov.mn/ цахим хуудсаар орж танилцана уу.
3 Лавлагаа авахыг хүсвэл 263942 дугаарын утсанд хандана уу.

**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН КАДАСТРЫН ХЭЛТЭС**

## АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БАРЬЦААЛАГЧ БАНК САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН АНХААРАЛД

2017 оны 9 дүгээр сард ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг хүснэгтэд заасан хугацаанд Ашигт малтмалын тухай хуулийн 32 дугаар зүйл болон 34 дүгээр зүйлийн 34.4-д заасны дагуу бүрэн төлж бүртгүүлэхийг хүсье.

| № | Код | Эзэмшигч | Барьцаалагч | Талбай (га) | Олгосон огноо |
|---|---|---|---|---|---|
| 1 | XV-008323 | Монголцамхаг | Анод банк | 1418,42 | 2004.09.09 |
| 2 | MV-012756 | Си Эф Си групп | Анод банк | 25,73 | 2007.09.27 |
| 3 | MV-017392 | Идэрголд | Голомт банк | 565,86 | 2013.09.30 |
| 4 | MV-011979 | Монгол-Анар трейд | Капитал банк | 376,08 | 2006.09.04 |
| 5 | XV-012028 | Цэвдэг | Капитал банк | 610,25 | 2006.09.19 |
| 6 | MV-012029 | Цэвдэг | Капитал банк | 139,05 | 2006.09.19 |
| 7 | XV-014195 | Ялгуун-Интернэйшнл | Капитал банк | 107,55 | 2008.09.23 |
| 8 | MV-001865 | Үүрттур | Капитал банк | 227,34 | 1999.09.17 |
| 9 | MV-017100 | Авдарбаян | Лэтфорекс | 28,44 | 2002.09.19 |
| 10 | MV-010551 | Бэрэнгрупп | Монгол улсын хөгжлийн банк | 565,47 | 2005.09.29 |
| 11 | XV-012685 | Алкалли метал монголиа | Фёрст Литиум Корпорейшн | 12410,94 | 2007.09.06 |
| 12 | MV-017131 | Монлаа | Хаан банк | 585,55 | 2012.09.12 |
| 13 | MV-016653 | Улз гол | Худалдаа хөгжлийн банк | 657,97 | 2010.09.09 |

1 Та тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрөө дараах дансанд тушаана уу.
Төрийн сан банк 100900000712 /Төгрөгийн/
2 Та холбогдох мэдээллээ http://mram.gov.mn/ цахим хуудсаар орж танилцана уу.
3 Лавлагаа авахыг хүсвэл 263942 дугаарын утсанд хандана уу.

**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН КАДАСТРЫН ХЭЛТЭС**

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

# Байгаль хамгаалагчид ТУУЛАХ ЧАДВАР САЙТАЙ УНААТАЙ БОЛЛОО



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН









...БОАЖ-ын сайд Д.Оюунхорол "Эдгээр бэрхшээлийг туулж давахад бидэнд туулах чадвар сайтай тээврийн хэрэгсэл маш чухал гэж аймаг, орон нутагт ажилладаг тусгай хамгаалалттай газрын удирдлагууд болон мэргэжилтнүүд байнга ярьдаг байсан...

Г.ГАНЧИМЭГ

Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд байгаль орчны салбарт сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд техникийн хамтын ажиллагаа, олон улсын төсөл хөтөлбөрүүд амжилттай хэрэгжиж байгаа юм. Энэ нь Монгол орны байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг зохистой ашиглахад үнэлж баршгүй хувь нэмэр оруулж, үр дүнгээ өгсөөр байгааг БОАЖ-ын сайд Д.Оюунхорол онцлон тэмдэглэж байна. Үүний нэг нь тус яам 2015 оноос Сэргээн босголтын зээлийн банкаар дамжуулан Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутагт менежментийг сайжруулах, биологийн олон янз байдлыг хамгаалах, орчны бүсийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор 11.5 сая еврогийн "Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох" төслийг амжилттай хэрэгжүүлж байгаа явдал юм. Энэхүү төсөл нь Монгол орны тусгай хамгаалалттай газар нутагт хөрөнгө оруулалт, санхүүгийн бодитой туслалцаа, дэмжлэг үзүүлж байгаагаараа онцлогтой. Төслийн хүрээнд тусгай хамгаалалттай газар нутгийн Хамгаалалтын захиргаадын материаллаг баазыг бэхжүүлэх, хамгаалалттай газар нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх, мэргэжилтнүүдийн чадавхийг дээшлүүлэх, орчны бүсийг дэмжих, байгалийн нөөцийн тогтвортой менежментийн загвар болгох олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа юм. Гэхдээ Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгуудын хэмжээ том, хүрч ажиллахад саад бэрхшээлтэй. Дэд бүтэц сул хөгжсөнөөс үер ус ихтэй болон цас зудтай үед явах боломжгүй болдог. Иймэрхүү нөхцөл байдлын улмаас эргүүл, хяналт, шалгалт, судалгаа, мониторнгийн ажлыг явуулахад хүндрэлтэй, улмаар чанаргүй болж, гүйцэтгэхэд саад бэрхшээлтэй байжээ. Харин өчигдөр Монгол орны төв болон зүүн бүсийн улсын тусгай хамгаалалттай газар нутаг болох Төв аймгийн Горхи-Тэрэлж, Хустай нуруу, Өвөрхангай аймгийн Орхоны хөндий, Архангай аймгийн Хангайн нурууны байгалийн цогцолборт газрууд, Булган аймгийн Зэд-Хантай, Бүтээлийн нуруу, Хэнтий аймгийн Онон-Балж, Хан Хэнтийн тусгай хамгаалалттай газар, Завхан аймгийн Отгонтэнгэр, Тарвагатай нуруу, Хөвсгөл аймгийн Улаан тайга, Дорнод аймгийн Дорнод Монгол зэрэг улсын тусгай хамгаалалттай 11 захиргаанд бартаат замын 15 автомашин, мөн мэргэжилтэн, байгаль хамгаалагч нарын өвөл, зуны 610 хос дүрэмт хувцасыг хүлээлгэн өгөх ёслолын ажиллагаа жанжин Д.Сүхбаатарын талбайд боллоо. БОАЖ-ын сайд Д.Оюунхорол "Эдгээр бэрхшээлийг туулж давахад бидэнд туулах чадвар сайтай тээврийн хэрэгсэл маш чухал гэж аймаг, орон нутагт ажилладаг тусгай хамгаалалттай газрын удирдлагууд болон мэргэжилтнүүд байнга ярьдаг байсан. Нөгөөтэйгүүр, хууль бус үйл ажиллагаа явуулж байгаа этгээдийн арга ажиллагаа илүү гэмт хэргийн шинжтэй болж байгааг бидэнд сүүлийн үед тохиолдож байгаа олон үйл явдал харуулж байна. Тухайлбал, саяхан Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын байрыг галдан шатаасан. Энэ бол нэлээд ноцтой, байгаль орчны салбарт тохиолдсон гэмт хэрэг. Удахгүй хууль, хяналтын байгууллагууд, мэргэжлийн хяналтын байгууллага, аймаг, орон нутаг, онцгой байдлын газрын дүгнэлтүүд гарч, энэ асуудлыг шийдвэрлэнэ. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн Хамгаалалтын захиргаадад хамгийн сүүлийн загварын "Ланд Крузер" машиныг олгосноор манай мэргэжилтэн, байгаль хамгаалагч нар хариуцсан газар нутагтаа богино хугацаанд бүрэн хүрч ажиллах, хууль бус ажиллагааг цаг алдалгүй таслан зогсоох боломж бүрдэж байгаад маш их баяртай байна. Гагцхүү эдгээр үнэ цэнэтэй техник хэрэгслийг бүрэн бүтэн байдлаар удаан хугацаанд зориулалтын дагуу ашиглах үүрэг хариуцлагаа сайтар ойлгож ажиллана гэдэгт итгэж байна" гэдгээ машины түлхүүр хүлээлгэн өгөх үеэр хэллээ.

Мөн өнгөрсөн оны арваннэгдүгээр сард Берлин хотод болсон хоёр орны Засгийн газар хоорондын хэлэлцээрийн үеэр төслийн II үе шатыг 13.5 сая еврогийн төсөвтэйгөөр хэрэгжүүлэхээр болжээ. Энэ төслийг манай улсын тусгай хамгаалалттай газар нутгийн баруун болон говийн бүсэд хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, төслийн техник эдийн засгийн үнэлгээ хийгдэж байгаа аж. ХБНГУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-ны Хөгжлийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга Кристиан Гласс "Үнэ цэнэтэй ажлыг хийж байгаа тусгай хамгаалалттай газрын мэргэжилтэн, ажилтнуудад дэмжлэг үзүүлж байгаад баяртай байна. Монгол Улсын газар нутгийн 18 хувь тусгай хамгаалалтад байдаг нь Герман улсын нийт газар нутгийн гуравны хоёртой тэнцэх юм. Монгол Улсын Засгийн газраас энэхүү өндөр үүргийг хүлээсэн байдаг. Нөгөөтэйгүүр, үлэмж хэмжээний газар нутгийг хамгаалахад хэрэгцээтэй тоног төхөөрөмж, ялангуяа найдвартай тээврийн хэрэгслээр хангах зайлшгүй шаардлагатай юм.

Энэхүү чухал ажлыг Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлэхэд нь Герман улсаас дэмжлэг үзүүлэн нийт 15 машиныг 11 тусгай хамгаалалттай газрын захиргаадад хүлээлгэн өгч байна. Энэ нь биологийн олон янз байдлыг хадгалан хамгаалахад чиглэсэн бидний хамтарсан төслийн нэг хэсэг юм. Энэ төслийн хүрээнд Герман улсаас нийт 25 сая еврог олгоно. Би саяхан судалгааны багийнхны хамтаар баруун аймгуудад томилолтоор ажилласан. Бидний хамтын ажиллагааны хүрээнд газар нутгийг тэлэх ямар боломж байгааг судалсан юм. Аймгуудын удирдлага, Тусгай хамгаалалттай газрын захиргааны захирлууд, байгаль хамгаалагчид, орон нутгийн иргэд байгаль хамгаалахад ямар их зүтгэл гаргаж байгаа болон чин сэтгэлээсээ ажиллаж байгаа нь надад гүн сэтгэгдэл төрүүлсэн. Ирээдүйд ч нягт хамтран ажиллана гэдэгт би итгэл төгс байна" хэмээсэн юм.

ДУРЬДАТГАЛ

# ДЭЭДСИЙН МИНЬ АМЬССАН НУТАГ



Миний уугуул нутаг Сүхбаатар аймгийн баруун өмнөд хязгаарт орших Баяндэлгэр сум. Энэ жил зуны эхэн сард бороо ороогүй гандуу байсан боловч долдугаар сард бороошиж сайхан зунжиж оны өвс гарахгүй ч мал тарга авах ногоотой болжээ. Өвгөн би бээр ная хол гарсан ч хаая нутгаадаа тэмүүлж, төрсөн бууцаа эргэх сайхан байдаг билээ. Энэ удаа наадам өнгөрөөд дээдсийнхээ гэгээрэл оршоосон тал нутгаараа явж, буянт сүргийнхээ ашиг шимийг хүртэж, нутгийн ахан дүүсээр айлчилж явахдаа бодолд буусан дурдтгалуудыг олонд хүргэх хүсэл төрөв. Манай сумын нутгийн хойд тал нь хээрийн ургамалтай урд тал нь хад чулуутай намхан уулархаг говийн бүст хамаарагдана. Хөдөө аж ахуйн нэгдэл тарахын өмнөх жилүүдэд нутгийн удирдлагын холч бодлогын ачаар амины мал нэлээд өссөн байв. Удалгүй нэгдэл тарж, нийгмийн өмчид тооцогддог малаа нэгдэлчиддээ хувааж өгсөнөөр малчид нь чамгүй малжсан билээ. Өнөөдөр улсад дээгүүр орох олон малтай суманд тооцогддог бөгөөд мянган малтай өрх 60 гаруй бий гэнэ. 1960, 70-аад онтой харьцуулахад хүмүүсийн аж байдал, зан заншил нутгийн өнгө нэлээд өөрчлөгджээ. Харин хүмүүс мал ахуйд явахдаа гэр орноо задгай орхиод явдаг нь хэвээрээ байгаа нь тал нутгийн хүмүүсийн уужуу тайван зан чанар эвдрээгүй бололтой. Борооны усаар тогтсон жижиг нуур, шалбааг бараадан сувай үхэр, адуу нь өнжин хонон зэлүүд орчинд идээшиж тайван амгалан. Малын хулгай зэлгий алга. Хот айлын усны тэргэн дээр эмээлтэй морьд багширч байдагсан. Харин одоо айл бүрийн үүдэнд мотоцикль зогсож байна.

Би хөдөө гурав хонохдоо гайхалтай нэг зүйл мэдрэгдсэн нь морьтой хүний бараа бараг харсангүй. Ихэнх айлууд суудлын, ачааны машинтай болжээ. Тэд нарны энерги зай хураагуур ашиглан цахилгаантай болж телевизор үзэж цахим утсаар хол ойр чөлөөтэй харьцах болжээ.

Залуучууд морь унахаа больж мотоциклоор явж малаа нааш цааш болгодог юм байна. Малын хариулга үндсэндээ үгүй болжээ. Бэлчээрийн малаа мориор хариулж зохих цагт нь тарга хүч авахуулдаг нь нүүдэлчин малчдын олон зуун жилийн уламжлалт соёл, шалгарсан арга даа.

Урьд малчид жилд наад зах нь дөрөв нүүнэ. Бууцнаасаа хаваржаанд, зун ногоо дагаж хоёроос доошгүй нүүнэ. Шар хогонд удаан суухыг тэвчдэггүйсэн. Намар нэг сар орчим оторлож малаа говилж тарга хүчийг чамбайруулна. Тэгээд хондондоо бууж өвөлжөөнийхөө өвсийг гамнана. Намрын сэрүүнд мал өлчиржиж тарга хүч нь тогтдог давуу талтай гэдэг. Одоо жилд хоёр удаа л нүүдэг гэнэ. Үүнээс болж малын бэлчээр ихээр талхлагддаг болжээ. Манай нутгийн адуу хэзээнээс хурдны угшилтай. Одоо ч хурдалсаар. Баяр наадам ойртоход залуучууд мориныхоо уяа сойлгыг тааруулахын зэрэгцээгээр сайхан морь, мөнгөн эмээл, хазаар, хударгаар гоёно. Молом, Гомбосүрэн, Луузан, Авирмэд, Балдан-Осор гээд алт мөнгөний нэр цуутай дархчуудтай байсан. Одоо тэдний залгамжлагч бараг алга. Монгол даяар алдартай Дариганга мөнгөн эдлэлийн өвөрмөц хийц өв соёл хумигдаж байгаа нь харамсалтай.

Сумын наадмаар уралдсан морио барьж пайз олгох морьтон олдохгүй шахам болжээ. Залуучууд уяа морьдоо мотоциклоор дагаж давхих сонирхолтой гэнэ. Морио унаж таван хошуу малаа адгуулах нь аль ч талаас харсан бэлчээрийн мал аж ахуйтны орхиж боломгүй соёл мөндөө.

Манай нутгийнхан бог малаа өдөрт хоёр удаа сааж чанартай сайхан цагаан идээ хийдэгсэн. Энэ ажил бүр орхигдсоноос малын ашиг шим буурч зэрлэг удам руугаа ойртож байна.

Нутгийн маань ногоон нөмрөг болсон ургамлын бүтцэд өөрчлөлт ажиглагдаж байна. Маш элбэг ургадаг агь, ерхөг, чихэр өвс, хазаар, харгана, дэрс ховордох янзтай. Морьтой хүн харагдахгүй өндөр ургадаг дэрс харагдсангүй. Дэрсний навч, үр, цэцгийг бүх төрлийн мал иднэ. Хаягаар нь ургасан ногоо хамгийн сүүлд ганддаг тул намар орой хүртэл сөл тасрахгүй. Өвөл дэрсний ёзоорыг мэрж өл авдаг малын тэжээлийн чухал ургамлын нэг. Манай сумын баруун урд хязгаарт "Аргалийн уул" нэртэй газар байдаг ч аргал байгаагүй. Харин одоо нутгийн гүн рүү аргаль, угалз цөөн тоогоор амьдрах болжээ. Жаахан тордвол идээших бололтой.

Манай суманд яахаа алдсан ядуу хүн байгаагүй. Амьдралд тачуу мөчүү мал цөөнтэй, ажил хийх чадвартай өрхөө малжуулахын тул өгөх малын тоог нэмэх, хугацааг уртасгах арга хэмжээ авахаар нутгийн удирдлагууд шийджээ. Асрах ах дүүгүй, ажиллах чадвар мөхөс, өндөр настай зүдүү хүмүүс нь сумын төвд байдаг бөгөөд тэдэнд төвийн албан газар, сайн санаат хүмүүс тусалж амьдрах нөхцлийг нь хангаж өгдөг байна. Нэгдэл байх үед байсан хамгийн нарийн, урт ширхэгтэй ноолуур өгдөг улаан ямааны цөм сүрэг тарж үгүй болжээ. Нутгийн өндөр ашиг шимтэй, орчин цаг уурт зохицсон өлчир малын омгийг сонгож чанарыг сайжруулах үржлийн ажил урсгалаараа явагдаж байна. Мал эмнэлгийг хувьд шилжүүлснээр малд халдварт өвчин гарсан үед вакцин тарьж орлого олдог бусад цагт ажил, орлогогүй малын эмчтэй болжээ. Монгол Улсын Үндсэн хуулийг хэрэгжүүлэхийн тулд малыг эмчилдэг, халдварт өвчнөөс сэргийлдэг байнгын ажилтай мал эмнэлэг, үржлийн ажлыг удирддаг улсын мэргэжлийн алба зайлшгүй шаардлагатай байгааг төр засаг анхаарах цаг болжээ. Халдварт өвчнөөс сэргийлэх тарилга, туулгыг цаг алдахгүй хийдэг хариуцлагатай мал эмнэлэггүйгээр энх сүрэгтэн болж чадахгүй нь ойлгомжтой.

**Өгөөмөр С.ДАМДИНСҮРЭН**

**2017 оны долдугаар сарын 30**

# ЗАВСАРЛАГА

Books “Ном” буланд тавтай морил

# ИХ ГЭРИЙН ЭЗЭГТЭЙ

**Үргэлжлэл.**

**Түрүүч нь №142 дугаарт**




Жеми тийнхүү гайхширан зогсож байтал Ван Дер Мерве гэнэт,

-Наашаа Голланд шуудангаар ирсэн үү?

-Үгүй. Шуудангийн тэргээр.

Өвгөн Жемийг дахин хөлөөс толгой хүртэл шинжин хараад эцэст нь,

-За яах вэ, ярилцья гэжээ.

Ийнхүү тэр оройдоо дэлгүүрийн цаад захад, Ван Дер Мервегийн суух байр болгож тохөөрөмжилсөн хэсэгт уулзаж ярилцав. Тэр бол нэгэн зэрэг гал тогоо, хоолны болон унтлагын өрөө болдог хоорондоо хамар хаалттай хоёр ор тавьсан умгар өрөө байлаа. Ханын доод хэсгийг шавар чулуугаар, дээд хэсгийг хүнсний зүйл зөөж авчирдаг сарампай хайрцгаар хийжээ. Хананд гаргасан дөрвөлжин нүх нь цонхыг орлодог байлаа. Бороотой үед тэр нүхийг банзаар хадна. Хоёр хайрцаг дээр тавьсан урт зузаан банз ширээ болж. Бөөрөөр нь тавьсан том хайрцаг эргэнэгийн үүрэг гүйцэтгэдэг аж. Ван Дер Мерве бол мөнгөндөө тун ч гар татуу хүн юм байна гэдгийг Жеми ойлгов. Ван Дер Мервегийн охин үг дуугүй хоол хийх зуур үе үе эцгийнхээ зүг харж байсан боловч Жемийн өөдөөс нэг ч удаа харсангүй. “Энэ бүсгүй яагаад эцгээсээ ингэж их айдаг юм бол” гэж Жеми бодов. Ширээний ард суущгаасан хойно Ван Дер Мерве,

-За залбирцгаая. Эзэн тэнгэр таны өгөөмөр хишгийг хүртэж байдагтаа баярлалаа. Бидний нүгэл хилэнцийг өршөөн хэлтрүүлж, шунал тачаалаас сэргийлэн хамгаалж байдагт тань гялайлаа. Урт нас, удаан жаргал хайрладагт тань баярлалаа. Тэнгэрт тэрсэлсэн буруу номтныг залхаан цээрлүүлдэгт тань баярлалаа. Амэн гээд амьсгаа авалгүй, охиндоо хандан,

-Хоолоо өгөөрэй гэжээ.

Хоол нь жаахан гахайн шарсан мах, гурван ширхэг төмс, нэг жижиг шар манжин байв. Жемид хамгийн бага хувь нь ногдлоо. Эрчүүд хоол идэх зуураа ярилцаж, Маргерет ганц ч үг дуугарсангүй. Хоол идэж дуусаад,

-Маш сайхан хоол байна, охин минь гэж Ван Дер Мерве бахархан өгүүлээд Жеми тийш эргэж,

-За ажил явдлаа ярьцгаая гэлээ.

-За тэгье, эрхэм ээ

Ван Дер Мерве тавиур дээрээс урт шавар гаанс авч жижиг савнаас тамхи нэрээд, утаан хөшигний цаанаас Жемийг анхааралтай ажиглан,

-Клипдрифтийн эрэлчид бүгдээрээ тэнэг. Эрэлчид олон, алмас бага бий. Бүтэн жил махаа идээд ганц атга schlenterrs –ээс өөр юм олохгүй байж болно гэхэд нь

-Миний мэдэхгүй үг шиг байна, эрхэм ээ гэв.

-Тэнэгүүдийн очир эрдэнэ. Хямдхан чулуу. Ойлгож байна уу.

-За… Ойлголоо, эрхэм ээ. Алмас хаанаас эрэхийг мэдэх хүн бий юу?

-Грекүүд мэднэ… гэхэд нь Жеми өөдөөс нь гайхширсанд,

-Умард нутагт суудаг африк овог аймгийнхан. Тэд нар том том алмас олдог. Заримдаа надад авчирч өгч бараа таваар арилжиж авдаг… гээд голланд өвгөн хуйвалдаан хийж байгаа мэт дуугаа намсган,

- Хаанаас олохыг би мэднэ гэлээ.

- Мистер Ван Дер Мерве та өөрөө тийшээ очихгүй яасан юм бэ? гэсэнд өвгөн санаа алдаад

- Дэлгүүрээ орхих арга алга даа. Хамаг юмыг минь хулгай авчихна. Надад тийшээ яваад алмас авчирч өгөх найдвартай хүн хэрэгтэй байна. Тийм итгэлтэй хүн олдвол би хэрэгтэй бүх багаж хэрэгслийг өгч, алмас хаанаас эрэхийг хэлж өгнө гээд тамхиа нэг сайн соров.

> ...Ван Дер Мервегийн суух байр болгож төхөөрөмжилсөн хэсэгт уулзаж ярилцав. Тэр бол нэгэн зэрэг гал тогоо, хоолны болон унтлагын өрөө болдог хоорондоо хамар хаалттай хоёр ор тавьсан умгар өрөө байлаа. Ханын доод хэсгийг шавар чулуугаар, дээд хэсгийг хүнсний зүйл зөөж авчирдаг сарампай хайрцгаар хийжээ. Хананд гаргасан дөрвөлжин нүх нь цонхыг орлодог байлаа. Бороотой үед тэр нүхийг банзаар хадна. Хоёр хайрцаг дээр тавьсан урт зузаан банз ширээ болж. Бөөрөөр нь тавьсан том хайрцаг эргэнэгийн үүрэг гүйцэтгэдэг аж. Ван Дер Мерве бол мөнгөндөө тун ч гар татуу хүн юм байна гэдгийг Жеми ойлгов...

Жемийн зүрх булгилан хөл дээрээ босон харайж,

-Мистер Ван Дер Мерве, Таны эрж байгаа хүн би мөн. Та надад итгээрэй. Би өдөр шөнөгүй ажиллана. Би танд тоолж барахгүй олон алмас авчирч өгнө гэж хэлэхдээ сэтгэл нь догдолсноос хоолой нь чичирч байлаа. Ван Дер Мерве Жемийг нэг хэсэг ажин шинжсэнээ,

-За гэж ганц үг дуугарав.

Маргааш өглөө нь Жеми гэрээнд гарын үсэг зурав. Гэрээг нь африк хэлээр бичсэн байлаа. Ван Дер Мервегийн хэлсэн нь,

-Одоо чамд учрыг хэлье. Энд чи бид хоёрыг бүтэн тэгш эрхтэй хамжаа түнш нар гэж бичсэн байгаа. Би хөрөнгө оруулж, чи биеийн хүчээ үнэлнэ. Бүх ашгийг тэгшхэн хувааж авна гэв.

Жеми Ван Дер Мервегийн барьж буй гэрээг хараад өдий төдий гадаад үгний дотроос хоёр фунт гэсэн мөнгөний нэрнээс өөр юм ойлгосонгүй. Тэр үгсийг хуруугаараа заан,

-Энэ ямар учиртай юм бэ гэсэнд,

-Энэ бол чамд чиний олсон алмасын тэн хагасын дээр би чамд долоо хоногт хоёр фунт нэмж төлнө гэсэн үг. Тэнд алмас бий гэдгийг би мэднэ. Гэхдээ чи олж чадахгүй байж болох юм. Тэгвэл чи ажлынхаа хөлсөнд эрхбиш хэдэн мөнгө авах болно гэв.

Энэ хүний хичнээн шударгыг Жеми гайхан,

-Эрхэм танд их баярлалаа гэсэнд

-За одоо чиний авч явах багаж хэрэгслийг бэлдэцгээе хэмээн Ван Дер Мерве хэлжээ.

Тэр хоёр Жемийн авч явах багаж хэрэгслийг хоёр цаг шилж сонгов. Жижиг майхан, унтлагын уут, тогоо шанага, хоёр шигшүүр, угаах хайрцаг, царил, хоёр хүрз, гурван хувин, дотуур хувцас, оймс. Энд бас сүх, дэнлүү, керосин, шүдэнз, саван байлаа. Хүнсний зүйл нь лаазалсан мах, хуурай үр жимс, кофе, давс гэх мэт байлаа. Эцэст нь бүх юм бэлэн болов. Негр зарц Банда энэ бүх юмаа шуудайлахад нь Жемид туслалаа. Банда Жемийн өөдөөс нэг ч удаа эгцэлж харсангүй, нэг ч дуугарсангүй. “Англи хэл мэддэггүй байх л даа” гэж Жеми бодлоо. Маргерет дэлгүүртээ худалдан авагчдад үйлчлээд завгүй байлаа. Жемийн энд байгааг мэдсэн ч гэсэн мэдээгүй дүр эсгэж байх шиг. Ван Дер Мерве хүрч ирээд,

-Чиний луус хаалганы тэнд байгаа. Юмаа ачихад чинь Банда чамд тусална гэхэд нь

-Мистер Ван Дер Мерве танд их баярлалаа гэж Жеми халуун сэтгэлээр талархав. Ван Дер Мерве баахан тоо бичсэн цаас харж:

-Чамаас 120 фунт авна гэхэд нь Жеми ойлгож ядан өөдөөс нь бүлтийн ширтэн

- Юу гэнэ? Та өөрөө хэлэхдээ... гэсэнд Ван Дер Мервегийн хилэн бадарч царай нь минчийн улайж,

-Чи намайг энэ бүх юмны дээрээс луусаа зүгээр өгч бас чамайг хамжаа түншээ болгоод дээр нь бас долоо хоног бүр хоёр фунт нэмж өгөх юм гэж бодов уу? Хэрэв чи намайг завших санаатай байгаа бол хүнээ олсонгүй... гээд луусны нуруунд ачсан шуудайг буулгахаар завдахад нь Жеми сандарч,

-Байз, байз. Би сайн ойлгоогүй бололтой. Зүгээр, зүгээр. Надад мөнгө бий гээд түрийвчээ гарган хадгалж үлдсэн бүх мөнгөө лангуун дээр гаргаж тавьсанд Ван Дер Мерве хэсэг эргэлзэж байснаа,

-За яах вэ. Чамайг сайн ойлгоогүй юм байж гэж бодьё. Энэ хотоор дүүрэн муусайн луйварчид байдаг юм. Би хамжаа түншээ сонгохдоо болгоомжлох хэрэгтэй гэхэд нь Жеми зөвшөөрч,

-Тийм л дээ, эрхэм ээ, нээрээ тийм гэжээ.

Сэтгэл нь хий хөөрөөд нэг юм дутуу ойлгосон бололтой. “Энэ хүн надад дахин нэг боломж олгосон нь овоо” гэж Жеми бодлоо. Ван Дер Мерве халаасаа уудлан үнгэгдсэн цаасан дээр гараар зурсан газрын зураг шуу юм гарган

-Энд байгаа. Магердамаас хойшоо Ваал голын хойт хөвөөнд гэхэд нь Жеми зургийг харж, зүрх нь булиглан

-Хэдэн милл хол вэ гэсэнд

-Энд газрыг хол ойрыг хоногоор хэмждэг юм. Луусаар явахад 4-5 хоноод хүрнэ. Буцах замдаа алмас ачиж ирэх тул илүү их хугацаа орно доо гэхэд нь Жеми инээд алдан,

-Тэгнэ гэжээ.

Жеми гудамжинд гарахдаа энгийн нэг жуулчин биш баяжих замаар явж байгаа эрэлчин болсон байлаа. Дэлгүүрийн үүдэнд уяатай луусанд Банда уутай юмсыг ачаад дуусаж байв.

-Баярлалаа гэж түүнийг инээмсэглэн хэлэхэд Банда өөдөөс нь нэг эгцлэн хараад үг дүүгүй яваад өгчээ. Жеми луусыг жолооноос нь барьж аваад

-Аян замдаа орцгооё, түншээ. Хөдлөх цаг боллоо гэж хэлээд умар зүгийг барин хөдлөлөө.

Шөнө нь Жеми голын дэргэд зогсож, луусны ачааг буулган усалж, өвс өгөв. Жеми өөрөө лаазалсан мах, хатаасан гүйлс идэж, кофегоор даруулав. Шөнө янз бүрийн чимээ авиагаар дүүрэн байлаа. Ус уухаар явж байгаа зэрлэг ан араатан архиран хүрхрэн, улин хуцах сонсогдоно. Залуу эр энэ дэлхий дээрх хамгийн аймшигт араатны дунд урьд үзээгүй бүдүүлэг улс оронд ямарч хамгаалалтгүй ганцаараа байлаа. Тэгээд өчүүхэн чимээ гарах бүрд давхийн цочиж, харанхуйгаас одоо юу юугүй ямар нэгэн араатан үсэрч ирээд хурц соёогоо биед нь шигтгэх болов уу гэж хүлээж байв. Бодол сэтгэл нь алслан оджээ. Тэгээд төрсөн гал голомтынхоо амгалан тайван амьдрал, тохилог ор дэвсгэрээ дурсан санав. Жеми дав дувхийн унтаж, догшин арслан заан бас бавгар сахалтай эрчүүл асар том алмас эрдэнийг нь булаах гэж байна хэмээн зүүдэлж хонов. Жемиг үүрээр сэрэхэд луус нь үхчихсэн байв.

**Үргэлжлэл нь дараагийн дугаарт**

Улаанбаатарт:



Маргааш

Өдөр 20
Шөнө 6



Нөгөөдөр

Өдөр 22
Шөнө 8

## Өдрийн зурхай

**НАМРЫН ЭХЭН ШАР БИЧ САР ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ ШАР ХУЛГАНА ӨДӨР**

**Наран ургах шингэх:** 06.06-19.39

**Үс засуулбал:** Нас уртасна



*Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эм засал хийлгэх, авшиг авах, бэрийн үйл, дайсныг дарахад болон хуран чуулах, үс угаахад сайн. Зүүн нүд татвал хувцас олдох, баруун нүд татвал тэмцэл болох, баруун чих хангинавал сайн, зүүн нь хангинавал өчүүхэн нэгнийг үзэх, тагнай загатнах, бие татвал үзэсгэлэн болох, хөлийн шөрмөс татвал үг, асуулт болно. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой.*

ТЭНГИС






35 настай эхнэр хүүхдийн хамт амьдардаг Төгөлдөр гэдэг нэртэй. Геологич мэргэжилтэй залуу шинэ ажил, шинэ албан тушаалд томилогдож байгаагаар кино эхэлнэ. Төгөлдөр гадаадад сургууль төгссөн, мэдлэг боловсролтой, ажилдаа сайн гэр бүлийн байдал тогтвортой боловч ганцхан асуудал болсон зүйлтэй...




Дэлхийн шилдэг бие хамгаалагч ОУ-н шүүхийн гэрчээр дуудагдах мэргэжлийн алуурчныг хамгаална.




Бяцхан охиныхоо эмгэнэлт үхлээс хойш нэлээд хэдэн жилийн дараа хүүхэлдэй урлагч эхнэрийн хамтаар асрамжийн газраас хэд хэдэн охидыг нэгэн гэлэнмаа хамтаар гэртээ хүлээн авах болно. Тэд харин хүүхэлдэй урлагчийн чөтгөрт эзэмдүүлсэн бүтээл болох Аннабеллийн бай болох тавилантай байснаа мэдээгүй юм.

